

Захирлын мэндчилгээ
Сургуулийн товч танилцуулга
Эрхэм зорилго, хэтийн төлөв, уриа
Боловсролын философи
2015 – 2020 оны 5 жилийн стратеги төлөвлөгөө
Сурагчийн зан байдлын төлөвшил буюу Сурагчийн эрхэмлэх чанар
Зөвшөөрөл, магадлан итгэмжлэл
Мэргэжлийн байгууллагын гишүүнчлэл
Сургуулийн зохион байгуулалт, хичээлийн цагийн хуваарь
Дунд Сургуулийн багшийн зөвлөх үйлчилгээ
Сурагчдын ирц
Сурагчийн хичээл таслалт, өвдөх
Сурагчдын цугларалт
Багийн систем
Хичээлийн дараах сургалтын хөтөлбөр
Сургууль, багууд хоорондын спортын үйл ажиллагаа (АСАМIS буюу Хятад Монголын ОУ-ын
Сургуулиудын Холбоо, спортын лиг)
Биеийн тамирын хичээлд тавигдах шаардлага
Дунд Сургуулийн сурагчдын Удирдах Зөвлөл, Бага Сургуулийн сурагчдын Манлайллын баг
ОУДС –ийн урлаг соёлын арга хэмжээ, үзэгчдэд тавих шаардлага
Аюултай нөхцөл байдал, гэнэтийн осол, анхны тусламж
Сургуулийн кафетери, хөнгөн зууш, төрсөн өдрийн баяр тэмдэглэх
Сургууль, багш, эцэг эхийн харилцаа холбоо
Сурагчдын сурах арга барилд дэмжлэг үзүүлэх тусгай үйлчилгээ
Номын сан, сургалтын материалын төв
Бичгийн хэрэгсэл Сурах бичиг ашиглах журам Тооны машин
Сурагчдын танилцах аялал
Танхимын бус сургалт
Round Square – IDEALS долоо хоногийн аялалууд
Сурагчийн үнэмлэх
Багш -эцэг эхийн бүлэг /PTG/
Эцэг эхийн сайн дурын оролцоо
Бага сургуулийн хичээлийн хөтөлбөр: Цэцэрлэгийн ангиас 5-р анги хүртэл
Дунд сургуулийн хичээлийн хөтөлбөр: 6-10 -р анги
Ахлах ангийн хичээлийн төлөвлөгөө: 11-12 -р анги
ОУДС -ийн хэлний сургалт
Сурагчийг үнэлэх, дүгнэх, тайлагнах
Гэрийн даалгавар
Сурагчийг урамшуулан шагнах
Сурагчдын ОУДС дээр биеэ авч явах соёл, зан байдалд тавигдах шаардлага
Хувцаслалт
Технологийн зөв зохистой хэрэглээг зохицуулах
Бидэнтэй холбогдох

Захирлын мэндчилгээ

Та бүхэнд Улаанбаатар дахь Олон Улсын Дунд Сургуулийн 2018-2019 оны хичээлийн жилийн мэндийг хүргэе.

Та бүхнийг манай хамт олны нэгэн хэсэг болж байгаад би туйлын баяртай байна.

Энэхүү гарын авлагаас манай сургуулийн бүтэц, дотоод дүрэм журам, ирээдүй, хэтийн төлөв зэрэг олон зүйлийг мэдэж авч болно. Хэрэв энэ авлагад та бүгдийн асуухыг хүссэн мэдээлэл багтаагүй бол хичээл, сурагчидтай холбоотой асуудлаар тухайн ангийг хариуцсан багштай чөлөөтэй уулзаж ярилцаж болно.

Харин бусад асуудлаар 70160010 дугаарын утсаар холбогдох буюу reception@isumongolia.edu.mn и-мэйл хаягаар хандсанаар тухайн асуудал хариуцсан ажилтнуудтай холбогдох болно.

Та бүхэнд ирэх жилдээ амжилттай, аз хийморьтой байхыг хүсэн ерөөе. Бид та бүхэнтэй хамтран ажиллахад үргэлж таатай байна.

Хүндэтгэсэн,

Билл Элман

Захирал

Жич: Энэхүү гарын авлага нь тогтмол хянагдаж, шаардлагатай тохиолдолд нэмэлт өөрчлөлт хийгддэг тул Сурагч, Эцэг эхчүүдэд зориулсан гарын авлагын хамгийн сүүлийн хувилбарыг тус сургуулийн вэб сайт (www.isumongolia.edu.mn) –с авах боломжтой. ОУДС–ийн вэбсайт эцэг эх, сурагчдад шаардлагатай илүү дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан болно.

Сургуулийн товч танилцуулга

ОУДС бол бие даасан, ашгийн бус олон улсын сургууль бөгөөд 1992 онд анх үүсгэн байгуулагдсан юм. Тус сургуулийн эцэг эхийн зөвлөл нь Жилийн эцсийн хуралдаанаар 11 хүртэлх гишүүний бүрэлдэхүүнтэй Төлөөлөн Удирдах Зөвлөлийг сонгодог. Америкийн Нэгдсэн Улсын дэмжлэгтэй ажилладаг сургууль болохын хувьд Улаанбаатар дахь АНУ –ын Элчин сайдын яамнаас нэмэлт саналын эрхтэй нэг гишүүнийг Удирдах Зөвлөлд томилон ажиллуулдаг юм. Удирдах зөвлөлийн саналын эрхгүй гишүүдэд тус сургуулийн захирал болон гүйцэтгэх захирлууд ордог.

Сургуулийн Удирдах Зөвлөл нь ОУДС-ийн стратеги, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавина. Сургуулийн захирал стратеги болон санхүүгийн төлөвлөгөөний үйл ажиллагааны хэрэгжилттэй холбоотой бодлого, журмыг боловруулах үүрэгтэй.

Эрхэм зорилго, хэтийн төлөв, уриа, үнэт зүйлс

ОУДС нь Дэлхийн ИВ хөтөлбөрийг сургуулийн өмнөх насны цэцэрлэгээс 12-р ангийн сургалтандаа хэрэгжүүлдэг. Тус сургууль Олон улсын бакалавриатын байгууллагын сургалтын эрхэм зорилго, үнэт зүйлсийг дэмжиж, идэвхижүүлсэн хөтөлбөрийг англи хэл дээр суурилан хэрэгжүүлдэг.

Дэлхийн бакалавриатын сургалттай сургууль болохын хувьд ОУДС нь ”олон үндэстний соёлыг ойлгож хүндэлсэн, нарийн чанд үнэлгээ дүгнэлт бүхий олон улсын түвшний мэдлэг боловсрол олгох, хүч чадал сорьсон хөтөлбөрүүдээрээ дамжуулан илүү сайн сайхан, амар амгалан дэлхий ертөнцийг бүтээлцэх, нэгтгэн дүгнэх чадвартай, өргөн мэдлэгтэй, хүнлэг залуусыг төлөвшүүлэхийг зорихын зэрэгцээ сурагчдыг идэвхитэй, бусдыг ойлгож, хүлээн зөвшөөрдөг, энэрэнгүй, зөв ёс суртахуунтай насан туршийн суралцагч болгох” –ыг эрмэлзэнэ.(ИВ,2014)

ОУДС –ийн эрхэм зорилго

Сурагчдаа дэлхий нийтийн хөгжил харилцаанд хувь нэмрээ оруулж, идэвхитэй оролцуулах үүднээс тэдний дахин давтагдашгүй чадавхи, нөөц бололцоог урамшуулан, хөгжүүлэхийн тулд бүх хүчээ дайчлан ажиллана.

ОУДС –ийн хэтийн төлөв

ОУДС нь дээд боловсролын суурь, амьдралын бэлтгэл болох дэлхийн түвшний, олон улсын боловсролыг Монголын өвөрмөц соёл, өв уламжлал бүхий орчинд эзэмших боломжийг сурагчдад олгоно.

ОУДС –ийн уриа

Сурагчдад

- Тархин дахь боловсрол
- Зүрхэн дэх нөхөрлөл
- Амьдрал дахь амжилтаараа өөрчлөлт хийхэд нь дэмжлэг үзүүлнэ.

Баримтлах үнэт зүйлс

ОУДС –ийн үнэт зүйлс бол бидний эн тэргүүнд тавигдах чухал зүйлсийн үндэс суурь бөгөөд биднийг өөртөө болон нийгэмдээ хариуцлагатай байлгахад үйлчилнэ.

Бидний баримтлах үнэт зүйлс:

- Тал бүрийн, өргөн мэдлэг боловсрол нь сурагчдын онцгой авьяас чадварыг нээн гаргахын хамтаар тэдний мэдлэг, бие бялдар, сэтгэлзүйн хөгжлийг тэнцвэржүүлдэг.
- Олон үндэсний соёлын орчин нь сурагчдад дэлхий ертөнцийг өргөн хүрээгээр харах, олон талт соёлыг ойлгох, түүнд талархах сэтгэгдлийг бий болгох боломжийг олгодог.
- Сурагчдад өөрсдийн үнэ цэнээ мэдэрч, бусадтай нийцтэй байх чадварыг олгоход чиглэгдсэн сургалтын орчин нөхцөл нь тэдэнд харилцан бие биенээ хүндэтгэх, халамжлах зан төлвийг хөгжүүлж өгдөг.
- Тэнцвэртэй боловсрол нь сурагчдыг хэцүү бэрх зүйлсийг даван туулахад хэрэгцээтэй заавар зөвлөгөөгөөр хангаж, өөртөө итгэлтэй байдал, идэвхи чармайлтыг нь дэмжин, тэднийг дунд сургуулийн дараах болон насан туршийн суралцах үйл явцад нь чиглүүлж өгдөг.
- Олон улсын сургууль нь сургалтыг чадавхижуулах чухал сурвалж болж өгч байдаг оршин буй орны хамтын ажиллагаагаар өргөжин тэлж байдаг.
- Боловсрол бол эцэг, эх, багш нар, ажилчид, сурагчид гэх мэт сургуулийн орчны бүх гишүүдийн дундын хариуцлага гэдэгт итгэдэг.

Боловсролын философи

ОУДС нь олон улсын бакалавриатын хөтөлбөрт суурилсан тэнцвэртэй боловсрол олгох хөтөлбөрийн хүрээнд дараах дөрвөн чиглэлийн боловсролыг сурагчдадаа эзэмшүүлдэг.

Боловсрол олгох үндсэн чиглэлүүд:

Танхимаар олгох мэдлэг боловсрол

ОУДС нь сурагчдын мэдлэг боловсрол, хүсэл эрмэлзлийг дээшлүүлэх, төгөлдөржүүлэхийг онцгойлон дэмждэг. Манай сурагчид өөрсдийн сурч боловсрох, өсч хөгжих эерэг дулаан уур амьсгал бүхий орчиндоо дуртай байдаг. Бидний нэг зорилго бол сурагч нэг бүрт амжилттай амьдрах, их дээд боловсрол амжилттай эзэмшихэд нь суурь болох дахин давтагдашгүй чадавх, нөөц бололцоогоо ашигладаг болоход нь туслах явдал юм.

Урлаг, соёл

ОУДС нь хөгжим, дүрслэх урлаг, жүжиглэх урлагийн боловсролыг олгодог, мөн хичээлийн дараах хөтөлбөрийн хүрээнд нэмэлт боломжуудыг санал болгодог.

Спорт арга хэмжээ

ОУДС нь сурагчдыг хичээлийн болон хичээлээс гадуурх үйл ажиллагаануудад идэвхитэй оролцуулах үүднээс төрөл бүрийн спорт арга хэмжээ зохион байгуулдаг.

Иргэншил

ОУДС өөрийн багш ажилчид, сурагчдыг ИВ хөтөлбөрт тусгагдсан зан байдлын төлөвшил, чанаруудыг эрхэмлэн бүх нөөц бололцоогоо ашигладаг байхыг нь уриалан дэмждэг.

2015 – 2020 оны 5 жилийн стратеги төлөвлөгөө

ОУДС нь өөрсдийн эрхэм зорилго, зорилтоо биелүүлэх, үнэт зүйлсээ даган баримтлахын тулд дараахи стратеги төлөвлөгөөг ирж буй 5 жилд баримтална. Үүнд:

- 1. Элсэлт Маркетинг:** Олон улсын шинж чанарууд болон ОУДС-ийн онцлог, давуу байдлыг сурталчилсан маркетингийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэн элсэлтийг нэмэгдүүлэх
- 2. Сурлагын амжилт:** Үр дүнтэй бүтэц, бодлогыг хэрэгжүүлэн сурагчдын сурлагын ерөнхий амжилтыг ахиулах
- 3. Сурагчдыг дэмжих үйл ажиллагаа:** Сурагчдад тусалж дэмжих бүтцийг боловсруулж хэрэгжүүлснээр суралцах үйл явц болон насан туршийн амьдралын чадамжийг сайжруулж урам зоригийг нэмэгдүүлэх
- 4. Мэдээлэл Харилцаа Холбооны Технологийн хэрэглээ:** Хичээлийн болон хичээлийн бус хөтөлбөрийн хүрээнд МХХТ-ийн үр дүнтэй, зорилго бүхий хэрэглээг хөгжүүлэн хэрэгжүүлснээр заах болон сурах үйл ажиллагааг сайжруулах
- 5. Олон нийтийн харилцаа:** ОУДС болон Монгол Улс, Олон улсын хүрээнд харилцан тустай үйл ажиллагаа болон харилцаа холбоог үүсгэх, дэмжих, тэмдэглэх үйл явцаа үргэлжлүүлэх
- 6. Эцэг эх, сурагчдын ойлголт, оролцоо, дэмжлэг:** ОУДС-ийн баримтлах үнэт зүйлс болон Олон Улсын Бакалавриатын хөтөлбөрийн талаар эцэг эх сурагчдын ойлголтыг гүнзгийрүүлж, тэдний оролцоог нэмэгдүүлэх

Дээрх зорилгууд нь ОУДС –ийн стратеги төлөвлөгөөг бүрдүүлэх бөгөөд бидний цаашид хийж гүйцэтгэх үүрэг даалгаврыг тодорхой харуулна. Эдгээр зорилгуудын аль нь ч бусдаасаа илүү чухалд тавигдахгүй, өөр хоорондоо хамааралтай, нэгнийх нь биелэлт нөгөө зорилгуудын биелэлтээс хамааралтай байна.

Сурагчийн зан байдлын төлөвшил буюу сурагчийн эрхэмлэх чанар /The Learner Profile/

Бүх ИВ хөтөлбөрийн зорилго бол хүн төрөлхтөн бид нэгэн дээвэр дор амьдарч энэ гараг дэлхийгээ хайрлан хамгаалах ёстой гэдгээ хүлээн зөвшөөрсөн, дэлхий ертөнцөө илүү сайн, энх амгалан байлгахад туслахын тулд олон улсын түвшинд сэтгэх чадвартай иргэдийг төлөвшүүлэхэд оршино.

Сурагчийн эрхэмлэх чанар /The Learner Profile/:

Эрэлхийлэгч

Бид төрөлхийн сониуч, сэтгэн бодох чадвараа хөгжүүлдэг. Бид бие даан эсвэл бусадтай хэрхэн суралцахыг мэддэг. Бид суралцах чин хүсэлтэй, энэ хүслээ насан туршдаа хадгална.

Сэтгэгч

Бид нарийн төвөгтэй, ээдрээтэй асуудлуудад шүүмжлэлтэй, бүтээлчээр хандаж, ёс зүйн үүднээс зөв зохистой шийдвэрүүд гаргадаг.

Үзэл бодлоо зөв чөлөөтэй илэрхийлэгч

Бид харилцааны олон хэлбэрийг ашиглан нэгээс илүү хэлээр аливаа мэдээлэл, үзэл санааг ойлгож, өөртөө итгэлтэйгээр үзэл бодлоо илэрхийлдэг. Бид бусадтай үр дүнтэй хамтран ажилладаг.

Өргөн мэдлэгтэй

Бид улс орны болон дэлхий нийтийн ач холбогдолтой концепци, үзэл санаа, асуудлуудыг судалдаг. Энэ явцдаа олон төрлийн хичээлээс өргөн ойлголт, гүн гүнзгий мэдлэг олж авдаг.

Ёс журамтай

Бид шударга ёс, үнэнч байдлыг эрхэмлэн, хувь хүн, бүлэг, хамт олны нэр төрийг хүндэтгэдэг. Бид өөрсдийн хийсэн үйлдэл, түүнээс гарах үр дагаварт хариуцлага хүлээдэг.

Хүнлэг энэрэнгүй, халамжтай

Бид бусдын санаа сэтгэл, хэрэгцээг хүндэтгэн үзэж, бусад өрөвч зөөлөн сэтгэлээр ханддаг. Хүмүүсийн амьдрал болон орчин тойрондоо эерэг нөлөө үзүүлж, бусдын төлөө үйлчлэх чин хүсэлтэй.

Бусдын үзэл бодолд хүндэтгэлтэй хандагч

Бид өөрсдийн түүх, соёлыг ойлгон нандигнаж, бусад хүмүүс болон хамт олны эрхэмлэдэг зүйлс, зан заншилд хүндэтгэлтэй ханддаг. Олон ургальч үзлийг үнэлж дүгнэн, туршлагаасаа суралцаж цаашид өсөж дэвжих хүсэл эрмэлзэлтэй байдаг.

Өв тэгш

Бид өөрсдийн болон бусдын сайн сайхны тусын тулд оюун ухаан, бие махбод, сэтгэл санааны өв тэгш тэнцвэрт байдал чухал гэдгийг ойлгож ухамсарладаг. Бид өөрсдийгөө амьдарч буй дэлхий ертөнц болон бусад хүмүүстэй холбоотой байдгийг мэддэг.

Дүгнэн бодогч

Бид өөрсдийн сурах үйл явц, туршлагад дүгнэлт хийж цаашдын хөгжилдөө анхаарч, өөрсдийн давуу, сул талыг ойлгож үнэлгээ өгөх чадвартай.

Өөртөө итгэлтэй, зоригтой

Бид шинэ, тодорхойгүй нөхцлийг урьдчилан харж, зоригтой ханддаг. Шинэ стратеги, үзэл санаа, үүргийг судлах бие даасан сэтгэлгээтэй. Өөрсдийн итгэл үнэмшлээ илэрхийлж хамгаалах зоригтой.

Зөвшөөрөл, магадлан итгэмжлэл

ОУДС нь Олон улсын сургуулиудын зөвлөл \CIS\ болон Шинэ Английн сургууль болон коллежуудын холбоо \NEASC\ -с магадлан итгэмжлэгдсэн. ОУДС нь Монгол дахь цорын ганц Олон Улсын Бакалавриат хөтөлбөр хэрэгжүүлэгч сургууль бөгөөд Олон Улсын Бакалавриатын бага сургуулийн хөтөлбөрийг \PYP\ сургуулийн өмнөх наснаас 5 –р анги хүртэл, дунд сургуулийн хөтөлбөрийг \MYP\ 6-10 –р ангид, диплом олгох хөтөлбөрийг \DP\11-12-р ангиудад хэрэгжүүлэх зөвшөөрөлтэй.

ОУДС –ийг магадлан итгэмжлэх, зөвшөөрөл олгох үйл ажиллагаа хамгийн сүүлд 2011 онд хийгдсэн. Харин дараагийн зөвшөөрөл олгох, дүгнэлт гарах (CIS, NEASC, EARCOS, ACAMIS, AAIE, TIE байгууллагуудын хамтарсан) шалгалт 2016 оны 11-р сард хийгдэхээр төлөвлөгдсөн. Бидний явцын болон төлөвлөлтийн анхны тайлан 2013 оны аравдугаар сарын нэгэнд хүргэгдсэн.

Мэргэжлийн байгууллагын гишүүнчлэл

ОУДС нь Олон улсын сургуулиудын зөвлөл \CIS\ болон Шинэ Английн сургууль болон коллежиудын холбоо \NEASC\, Олон Улсын Бакалавриат түвшний сургалтын байгууллагаас гадна Зүүн азийн бүсийн гадаад сургуулиудын зөвлөл \EARCOS \, Хятад болон Монголын олон улсын сургуулиудын холбоо \ACAMIS\, Олон Улсын сургуулиудын холбоо \AAIE\ -ны идэвхтэй гишүүн юм. ОУДС нь мөн Олон улсын боловсрол олгогч, судалгааны байгууллага болон олон улсын зэрэгт ажил олгогч байгууллагад гишүүнчлэлийн бүртгэлтэй.

Сургуулийн зохион байгуулалт, хичээлийн цагийн хуваарь

Сургуулийн зохион байгуулалт

ОУДС нь бага болон дунд сургууль гэсэн хоёр хэсэгтэй. Бага сургуульд цэцэрлэгийн ангиас 5 хүртэлх анги хамрагдана. Дунд сургуулийн хэсэгт 6-12-р анги ордог.

Хичээлийн цаг

Өглөөний 8 цаг 10 минутад хонх дуугарч хичээлийн өдрийг эхлүүлнэ. Тиймээс бүх сурагчид өглөөний 8 цаг 10 минутын хонх дуугарахаас өмнө хичээлийн танхимд орж ирсэн байх хэрэгтэй. Ирцийг 8 цаг 10 минутад бүртгэнэ. Өглөөний 8 цаг 10 минутаас хойш ирсэн сурагчид хүлээн авах дээр хоцорсон минутаа бүртгүүлнэ.

Хичээлийн 7 өдрийн хуваарь

Хичээлийн өдрүүд 1-7 хүртэл тоогоор дугаарлагдана. 8 дугаар сарын 21-ний өдөр буюу хичээлийн эхний өдөр “1-р өдөр” гэж тооцогдоно. Сурагчид өнөөдөр ямар хичээлтэйгээ мэдэхийн тулд тухайн өдрийн дугаарыг мэдэх хэрэгтэй. Эдгээр

Эцэг эх, сурагчийн гарын авлага

өдрүүдийн дугаарыг сургууль дээр болон сургуулийн вэбсайтад байршуулдаг. ОУДС-ийн хуанлигаас хичээлгүй өдрийг мэдэж болох бөгөөд тухайн өдөр хичээл орохгүйг дугаарлаагүйгээр нь мэдэх боломжтой.

2018-2019 оны хичээлийн жилийн хичээлийн өдрүүдийн дугаарлалт хуанлид тэмдэглэгдсэн бөгөөд дахин өөрчлөгдөхгүй. Тиймээс хэрэв хичээлийн өдрүүдэд урьдчилан төлөвлөөгүй тасалдал гарвал тухайн тасалдсан өдрийг дахин төлөвлөх боломжгүй юм.

Хичээлийн цагийн хуваарь*

Бага анги (Цэцэрлэгийн анги- 5 дугаар анги)				Дунд анги (6-12 дугаар анги)		
Цаг	Үргэлжлэх хугацаа	Хичээлийн цаг	Тайлбар, ангиуд	Цаг	Үргэлжлэх хугацаа	Хичээлийн цаг, Тайлбар
08:10-08:20	10	Анги даасан багшийн цаг		08:10-08:20	10	Зөвлөх багшийн цаг
08:20-09:05	45	1		08:20-08:25	5	Анги солих цаг
09:05-09:50	45	2		08:25-09:20	55	1
09:50-10:00	10	Зуушны цаг		09:20-09:25	5	Анги солих цаг
10:00-10:20	20	Завсарлага		09:25-10:20	55	2
10:20-11:05	45	3		10:20-10:35	10	Завсарлага
11:05-11:50	45	4		10:35-10:40	5	Анги солих цаг
11:30-12:10	40	А Үдийн Хоол	К-Gr2	10:40-11:35	55	3
11:50-12:30	40	В Үдийн Хоол	Gr3-Gr5	11:35-11:40	5	Анги солих цаг
12:10-12:45	35	5		11:40-12:35	55	4
12:45-13:30	45	6		12:35-13:15	40+5	Үдийн хоол + Анги солих цаг
13:30-14:15	45	7		13:15-14:10	55	5
14:15-15:00	45	8		14:10-14:15	5	Анги солих цаг
15:00-15:10	10	Анги даасан багшийн цаг		14:15-15:10	55	6
15:15-16:00	45	Бага, дунд ангийн сурагчдын хичээлийн дараах сургалтын хөтөлбөрт багтсан үйл ажиллагаа				

*Дугуйлангийн хичээлүүд Даваа, Баасан гарагуудад орохгүй. Даваа гараг бүрт багш нарын хуралтай, Баасан гараг бүрт багш нар 15:30 хүртэл ажиллана.

Эцэг эх, сурагчийн гарын авлага

Дунд сургуулийн багшийн зөвлөх үйлчилгээ

Анги тус бүрийг нэг эмэгтэй, нэг эрэгтэй багш хариуцан ажиллах бөгөөд эдгээр багш нар таны хүүхдийг тухайн хичээлийн жилийн туршид анхаарч, туслалцаа дэмжлэг, зааварчилгаа өгч, тухайн сурагчийн эцэг эх, асран хамгаалагчидтай холбоотой ажиллана. Энэ нь эцэг эх сургуультай холбогдоход илүү хялбар болж байна гэсэн үг. Мөн сургуулийн удирдлага, хөтөлбөрийн зохицуулагчид ч энэ хөтөлбөрт оролцож, тусламж дэмжлэг өгч зөвлөнө. Энэ талаарх таны санал хүсэлтийг дуртайяа хүлээн авах болно.

Сурагчдын ирц

Сурагч бүхэн хичээлдээ оролцох нь зүй ёс. Тасалсан шалтгааныг тухайн сурагчийн эцэг эх, асран хамгаалагчид бичгээр анги хариуцсан багшид хүргүүлэх ёстой. Анги даасан, зөвлөх багш нар тухайн сурагчийн удаан хугацааны хичээл завсардалт, байнгын хожигдолт, хичээл таслалтыг бага, дунд сургуулийн эрхлэгчдэд бичгээр тайлагнана.

Хоцролт/ таслалт: Хичээлд тогтмол оролцох нь сурагчийн сурах үйл явц болон сурлагын амжилтад чухал нөлөө үзүүлдэг бөгөөд бүх багш нар хичээл таслахгүй, хоцрохгүй байхыг анхааруулж шаардах үүрэгтэй. Сурагчид хичээлийн өдрүүдийн 90%-д оролцох ёстой. Хичээлд суугаагүй өдөр нь 18 өдрөөс хэтэрвэл сургууль журамд заасны дагуу арга хэмжээ авна.

Багш нар сурагчийн бүтэн болон хагас өдрийн хичээлд суугаагүй талаар хангалттай үндэслэл бүхий тайлбарыг эцэг эх, асран хамгаалагчаас амаар болон бичгээр шаардах эрхтэй.

Эцэг эхчүүд хичээлийн үеэр урьдчилан төлөвлөсөн удаан хугацааны чөлөө авах шаардлагатай бол сургуульд заавал урьдчилан мэдэгдэх шаардлагатай. (SOR 6-Е журмыг үзнэ үү)

Сурагчид хичээлдээ хоцорч ирсэн тохиолдолд...

Өглөөний 8:10 цагаас хойш ирсэн сурагчид үүдэнд хүлээн авахад бүртгүүлэх хэрэгтэй. Удаа дараа өглөөний 8:10 цагаас хойш ирсэн сурагчийн эцэг эхтэй бага, дунд сургуулийн эрхлэгчид холбогдоно. Бүх ангийн багш нар сурагчдын ирцийг Managebac программ-д бүртгэнэ. Журам SOR 6-Е-д зааснаар 5 хоцролтыг 1 таслалт гэж тооцно.

Сурагчид хичээлийн өдөр сургуулиас явахыг хүсвэл...

Сурагчид бага, дунд сургуулийн эрхлэгчдийн (тэднийг эзгүй тохиолдолд Захирал) зөвшөөрөлгүйгээр сургуулиас гарч явахыг хориглоно (зохион байгуулалттай аялалд оролцоогүй тохиолдолд адилхан). Сурагч эцэг, эх, асран хамгаалагчийн бичгээр гаргасан хүсэлтийн дагуу хичээл тарах цагаас өмнө сургуулийг орхин явж болно. Энэхүү хүсэлт нь анги хариуцсан багш буюу хүлээн авахад урьдчилан хүргэгдсэн байх шаардлагатай.

Гадна завсарлага

Бага сургуулийн бүх сурагчид 10:00 цагийн болон өдрийн хоолны завсарлагаар гадаа гарч тоглоцгоодог. -25 градусаас хүйтэн цаг агаарт сурагчид гарахгүй дотор

Эцэг эх, сурагчийн гарын авлага

завсарладаг. Тиймээс та бүхэн өдөр бүр хүүхдүүдээ тухайн өдрийн цаг агаар болон хүйтэн, цастай үед гадаа тоглоход тохиромжтой хувцаслаж байгаарай.

Сурагчийн хичээл таслалт, өвдөх

Хэрэв таны хүүхэд өвчтэй эсвэл хичээлд ирэхгүй байх шаардлага гарсан бол өглөөний 8:10 минутаас өмнө хүлээн авахад мэдэгдэх эсвэл уг шалтгааныг тайлбарласан захидлыг анги даасан, зөвлөх багшид цахим шуудан эсвэл managebac ашиглан илгээх хэрэгтэй.

Ирц болон сурлагын амжилт нь өөр хоорондоо хамааралтай. Тиймээс сургуулийн дүрмийн дагуу сурагчид хичээлдээ байнга ирж байх хэрэгтэй.

Хичээлийн өдөр сурагч өвдөх

Хэрэв сурагч өвдөж, гэр лүүгээ явах шаардлагатай болсон бол багш тухайн сурагчийг сургуулийн эмчид хүргэж өгнө. Эмч тухайн сурагчийн ар гэрийнхэнтэй холбогдоно. Шаардлагатай тохиолдолд эмч бага, дунд сургуулийн эрхлэгчид тухайн сурагчийг гэрт нь хүргэх шаардлагатай байгаа талаар мэдээлэх ба өвдсөн сурагчийг түүний эцэг, эх, асран хамгаалагч ирж авах ёстой.

Цаг товлолт

Хүүхдийнхээ аливаа цагийг товлохдоо(жишээ нь: шүдний эмчийн цаг) хичээлийн дараа товлону уу. Хэрвээ боломжгүй бол ангийн багшид мэдэгдэх бичиг хүүхдээрээ өгч явуулж байна уу. Сурагчид сургуулийн байрнаас гарч явах болон буцаж орж ирэхдээ бүртгүүлэх шаардлагатай.

Гэр бүлийн аялал, амралт

Сургуулийн амралтын хуваарь хангалттай хугацааг гэр бүлүүдэд өгдөг. Иймээс сургууль улирлын амралтын хугацааг сунгахыг дэмждэггүй. Иймэрхүү хичээл таслалт нь анги бүлгийн, сурагчийн хичээлийн үзүүлэлт болон бидний хүүхэд бүрт олгох гэж хичээдэг дэг журам, аливаа зүйлд хариуцлагатай хандах хандлагад муугаар нөлөөлдөг. Эцэг эхчүүд дараагийн хичээлийн жилийн урьдчилсан төлөвлөгөөг хуанлигаас харж, амралт аялалаа бүтэн жилийн өмнөөс хуваарийн дагуу зохион байгуулах шаардлагатай.

Хүндэтгэн үзэх шалтгаанаар улирлын амралтыг сунгах шаардлагатай бол эцэг эхчүүд энэ талаар заавал урьдчилан бичгээр мэдэгдэж хүсэлт гаргах ёстой. Зөвшөөрөгдөөгүй хичээл таслалтын хугацааны хичээл болон даалгаварыг багш нар нөхөж өгөх үүрэггүй гэдгийг анхаарна уу.

Сурагчдын цугларалт(Assemblies)

Сурагчдын цугларалт нь тодорхой цагт бага болон дунд сургуулийн хөтөлбөрийн хүрээнд тус тусдаа тогтмол зохион байгуулагдана. Хичээл, цагийн хуваариудын талаархи цугларалт нь хичээлийн жилийн эхэнд төлөвлөгдөнө. Эцэг эх, сургуулийн бусад гишүүд сурагчдын цугларалтанд оролцох боломжтой.

Багийн систем

ОУДС-ийн багийн системийн зорилго нь сургуулийн уур амьсгалыг дээшлүүлэх, хөтөлбөр дэх сурагчийн эрхэмлэх шинж чанаруудыг хөгжүүлэх, сургуультай холбоотой бүлгүүдийг дэмжих явдал юм.

Бүх сурагч, багш ажилчид (захиргааны хамт олон, биеийн тамир хариуцсан захирал, биеийн тамирын багш нараас бусад) улаан, хөх, шар, ногоон гэсэн 4 багийн аль нэгэнд харьяалагдана. Төрсөн ах дүүс нэг багт орно. Бусад тохиолдолд аль багийн хуваарилалт нь тохиолдлоор сонгох журмаар хийгдэнэ. Сурагчид болон сургах боловсон хүчин **багийн өдөр** зарлагдах бүрт өөрсдийн харьяалагдах багийн өнгөтэй хувцас өмсөнө.

Энэ системийн гол онцлог нь сурагчид сургуулийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцон, зан төлвийн эрхэмлэх шинжүүдийг үлгэрлэн, биечлэн харуулсныхаа төлөө багтаа оноо нэмнэ. Тухайн хичээлийн жилийн турш баг хооронд зохиогдох төрөл бүрийн тэмцээнээр багтаа оноо цуглуулах боломжтой. Хичээлийн жилийн турш багийн оноог сургууль олон нийтэд зарлан, хичээлийн жилийн эцсийн хаалтын хурал дээр тухайн жилийн ялагч багийг шалгаруулна.

Хичээлийн дараах сургалтын хөтөлбөр

ОУДС –ийн хичээлийн дараах сургалт нь тухайн сургуулийн сурагчдын суралцах үйл ажиллагааг тэлэх зорилгынхоо хувьд хоёрдогч байдлаар тооцогдоно.

Энэ үйл ажиллагаа нь сурагчдад дараах боломжийг олгоно. Үүнд:

- Амьдралд бүх талаар өв тэгш, тэнцвэртэй байх
- Насны хувьд ялгаатай, өөр өөр соёлтой сурагчидтай нийцэн зохицох
- Шинэ ур чадвар эзэмшин, шинэ сонирхлыг бий болгох
- Сурагчдын эрхэмлэх зан чанарт тусгагдсан шинж чанарыг төлөвшүүлэх

Хичээлийн дараах төлөвлөгөөт үйл ажиллагаанууд нь 1-12-р ангийн сурагчдад Мягмар, Лхагва, Пүрэв гарагийн өдрийн 3:15-4:00 цагт явагдана. /жич: Зарим үйл ажиллагаа 4:00 цагаас хойш дуусах нь бий/.

Сургуулийн дүрэм журам уг үйл ажиллагаанд сургуулийн гадна, дотор зохиогдсоныг үл харгалзан хүчин төгөлдөр үйлчилнэ. Хичээлийн дараах сургалтын төлөвлөгөө нь тухайн хичээлийн жил эхэлсэн даруй мөн эхэлнэ. Спорт, зураг, гар урлал, шинжлэх ухаан, сонирхлын клубууд, сурагчдын засаглал, хөгжим, болон жүжгийн дугуйлангууд нь хичээлийн дараах сургалтын үйл ажиллагаануудын жишээ юм.

Дугуйлангуудын хөтөлбөр боловсруулагдсаны дараа бага сургуулийн хүүхдүүд долоо хоногт дурын 2 дугуйланд хамрагдах боломжоор хангагдана. Харин дунд сургуулийн хүүхдүүд хөтөлбөрийн удирдагчийн зөвшөөрлийн дагуу 3 хүртэлх дугуйланд оролцох боломжтой.

Тусгай тоног хэрэгсэл болон бусад шаарлагатай зардлуудтай холбоотойгоор зарим сургалтууд тодорхой хэмжээний төлбөр авах шаардлага гардагийг анхаарна уу.

Эцэг эх, сурагчийн гарын авлага

Сургууль, багууд хоорондын спортын үйл ажиллагаа (АСАМИС, УВАС спортын лиг)

ОУДС –ын биеийн тамирын захирал тухайн хичээлийн жилд төрөл бүрийн сургууль болон баг хоорондын спортын үйл ажиллагааг зохион явуулдаг.

ОУДС нь хөвгүүд, охидын гар бөмбөг, сагсан бөмбөг, хөл бөмбөгийн багуудыг АСАМИС лигийн тэмцээнд оролцуулдаг юм. Мөн ОУДС-ийн багууд Улаанбаатар хотын бусад сургуулиудын багуудтай тоглолтууд зохион байгуулдаг. Энэ нь ОУДС-ийн багуудыг АСАМИС лигийн тэмцээнд оролцохын өмнө туршлага хуримтлуулах сайн талтай.

Сургуулийг төлөөлөн гадаад орнууд руу явах сурагчдад тавигдах шаардлага (АСАМИС, ISCMS, GIN, ETC)

Гадаадын орнуудад зохион байгуулагдаж байгаа үйл ажиллагаанд сургуулиа төлөөлөн сурагчид оролцоно гэдэг сайшаалтай хэрэг юм. Гэвч ОУДС-ийн журмыг нэг л сурагч зөрчсөн тохиолдолд ОУДС-ийг төлөөлөн оролцож байгаа багийн бусад гишүүдийн аюулгүй байдал, саадгүй зорчих нөхцлийг эрсдэлд оруулах магадлалтай гэдгийг хүн бүр ойлгох нь чухал. Иймээс ОУДС-ийн нэр хүндэд нөлөөлөх, өөрийгөө болон бусдыг эрсдэлд оруулах үйлдэл гаргаж болзошгүй гэж үзвэл тухайн сурагчийн оролцоог түдгэлзүүлнэ. ОУДС –ийн шийдвэр нь голч шударга бөгөөд эцсийнх байна.

Биеийн тамирын хичээлд тавигдах шаардлага, тусгай мэдээлэл

Бүх оролцогчдын аюулгүй байдал, ая тухтай нөхцлийг хангах үүднээс сурагчид биеийн тамирын хичээлд бэлтгэлтэй ирэх шаардлагатай. Уг хичээл орох хуваарьтай өдөр 6-аас дээш ангийн сурагчид сольж өмсөх биеийн тамирын хувцастай ирнэ.

Биеийн тамирын боловсролын тэнхим нь сурагчдыг цэвэр агаарт байнга гаргахыг чухалчилдаг юм. Тиймээс сурагчдыг боломжтой үед гадаа агаарт байлгахыг хичээдэг. Таны хүүхэд Улаанбаатарын цаг агаар, улирлын нөхцөл байдалд бэлтгэгдсэн байх нь чухал юм. Иймд тохирсон хувцас хэрэглэл, нарны хамгаалалт, малгай зэргийг хэрэглэж байх нь зүйтэй.

Сурагчид биеийн тамирын хичээлд ирэхдээ дараах зүйлийг сайтар анхаарах хэрэгтэй.

Тохиромжтой хувцас: будаг гардаггүй спорт гутал, биед эвтэйхэн цамц, өмд (даашинз, банзал, жинс нь тохиромжгүй)

Ус: Ам хатах, цангах байдлаас зайлсхийн өөрсдийн нэрийг сайтар бичсэн усны савыг авчрах шаардлагатай.

Үнэт эдлэл: Аюулгүй байдлын үүднээс бугуйн цаг, хүзүүний зүүлт, ээмэг, бугуйвч гэх мэт үнэт эдлэл зүүхгүй байх. Эдгээр зүйлсийг гэртээ орхих эсвэл биеийн тамирын хичээлтэй өдөр сурагчдын шүүгээнд хадгалж болно.

Үс: Урт үстэй сурагчид үсээ боосон байх.

Эцэг эх, сурагчийн гарын авлага

Өвчин, гэмтэл: Хэрэв таны хүүхэд өвчтэй эсвэл гэмтлийн улмаас хичээлдээ оролцож чадахгүй тохиолдолд эмч, эсвэл эцэг эхээс бичиг ирүүлэхийг шаардана.

Жич: Эдгээр шаардлагуудыг хангаагүй сурагчид биеийн тамирын багш аюултай гэж үзсэн тохиолдолд хичээл болон бусад спортын үйл ажиллагаанд оролцох боломжгүй.

Дунд сургуулийн Сурагчдын зөвлөл, Бага сургуулийн сурагчдын Манлайллын баг

ОУДС –д суралцаж байгаа сурагч бүр сургуулийн салбар, хэсэг бүрт өөрсдийн дуу хоолойг хүргэх төлөөлөлтэй байна. Эдгээр нь Дунд сургуулийн Сурагчдын Зөвлөл болон бага сургуулийн сурагчдын Манлайллын Баг юм. Эдгээр нь сурагчдыг удирдах, тэдэнд үйлчлэх, сурагчид болон томоохон хэмжээний бүлэгт зориулсан төрөл бүрийн үйл ажиллагааг зохион байгуулна.

Дунд сургуулийн хувьд, Сурагчдын зөвлөлийн удирдлага нь Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч, Нарийн бичиг, Хөрөнгө бүртгэгчдээс бүрдэнэ. Хичээлийн жилийн эхэнд сонгууль болох бөгөөд энэ үед бүх ангиуд зөвлөл дэх өөрсдийн төлөөллийг сонгоно.

ОУДС - ийн урлаг соёлын арга хэмжээ - үзэгчдэд тавих шаардлага

ОУДС –д интернэйшнлизм буюу олон нийтийн эв нэгдэл, соёлыг эрхэмлэх хүндэтгэх үүднээс сургуультай холбоо хамааралтай бүлэг, хамт олонд өөрийн сургуулийн урлаг, соёлын арга хэмжээнд баримталдаг, олон улсын хэмжээний зарчмыг сануулах нь зүйтэй.

Аль ч урлаг, соёлын арга хэмжээний хувьд, зарлагдсан цагтаа орох хаалга хаагдаж, тайзан дээр үйл ажиллагаа албан ёсоор эхэлнэ.

Арга хэмжээний үед танхимд утсаар ярих, юм идэх, уухыг хориглоно. Үзэгчдийн ийм байдал нь тайзан дээр үзүүлбэрээ гүйцэтгэж буй сурагчдын анхаарлыг сарниулдаг. Тиймээс сурагчдыг тайзан дээр байх үед танхимд бусдын анхаарлыг сарниулах зүйл хийхгүй, дуу чимээ гаргахгүй байхыг хүсье. Бид сурагчиддаа жинхэнэ тоглолт ямар байдгийг хичээнгүйлэн зааж сургаж байдаг.

Хэрэв эцэг эхчүүд та бүхэн зураг авахыг хүсвэл бусад үзэгчид, тайзан дээрх сурагчдыг хүндэтгэн үзэх хэрэгтэй. Ялангуяа iPad гэх мэт таблетуудаар зураг авах тохиолдолд ард чинь сууж буй үзэгчдэд саад болдог төдийгүй, гэрэл нь тайзан дээрх сурагчдыг сарниулдгийг анхаараарай.

Хэрэв бага насны хүүхэд тань бүтэн цагийн турш сууж үзвэр үзэж чадахгүй бол тэднийг гэртээ харгалзан хамгаалах хүнтэй үлдээнэ үү. Үзэгчид чимээ шуугиантай, замбараагүй байх нь үзүүлбэр үзүүлж буй сурагчдад хүндэтгэлгүй санагддаг.

Эцэг эх, сурагчийн гарын авлага

Аюултай нөхцөл байдал, гэнэтийн осол, анхны тусламж

Багш ажилчдаас бүрдсэн Аюулгүй байдлын зөвлөл нь тус сургууль дээр аюултай нөхцөл байдал үүсэх тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагааны зарчмыг байнга хянан, шинэчилж ажилладаг.

Эдгээр үйл ажиллагаанд нүүлгэн шилжүүлэлт, гэнэтийн халдлага, газар хөдлөлтийн үеийн үйл ажиллагаа, тэдгээртэй холбоотой сургуулилтууд багтана.

Нүүлгэн шилжүүлэлт

Аюулгүйн хонхны үргэлжилсэн дуу нь сургуулийн барилгыг орхин гарах дохио болох буюу цахилгаан тасарсан үед чанга яригчаар зарлаж нийтэд мэдэгдэнэ. Хэрэв эцэг эх, бусад зочид сургууль дотор байхад байгууламжийг орхих дохио дуугарвал өөрт хамгийн ойр байх гарцаар гарч сургуулийн биеийн тамирын талбайд сурагч, багш ажилчдын эгнээний баруун талд нэг эгнээ үүсгэн жагсана.

Гэнэтийн осол, эмнэлгийн онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд, сургуулийн эмч, анхны тусламж үзүүлэхээр бэлтгэгдсэн багш, ажилчид сурагчдад шаардлагатай анхны тусламжийг шууд үзүүлнэ. Эмнэлгийн тусламж хэрэгтэй бол эмч шаардлагатай алхмуудыг гүйцэтгэнэ. Тухайн сурагчийн эцэг эхтэй холбогдож, уг сурагчийг түргэн тусламж үзүүлэх эмнэлэг эсвэл харьяалагдах эмнэлэгт хүргэнэ.

Сургуулийн кафетери, хөнгөн зууш, төрсөн өдрийн баяр тэмдэглэх

“GATE” ХХК-ий хариуцан ажиллуулж байгаа сургуулийн цайны газрын хаалга бүгдэд нээлттэй. Тухайн сарын хоолны цэсийг тус сургуулийн вэбсайтад байршуулна. ОУДС нь эрүүл хооллох хэвшлийг дэмждэг тул өөрийн хоолны газартаа хийжүүлсэн ундаа, чихэр худалдахыг хориглодог.

Төлбөр хийх хэлбэрүүд: ОУДС-ийн цайны газрын зориулалттай карт уншуулах, өөр бусад банкны карт уншуулах, төлбөрийг бэлэн төгрөгөөр хийх боломжтой. Эцэг эхчүүд сургуулийн цайны газар өөрийн биеэр очиж хүүхэддээ данс нээлгэх болон төлбөр хийж болно.

Та бүхэн хүүхдийнхээ хоолны төлбөрийн дансыг тогтмол шалгаж цэнэглэж байх шаардлагатай. Хэрвээ та цайны газарт хүүхдийнхээ хоолны төлбөрийг төлөөгүй тохиолдолд сургууль таны хүүхдийн дүнгийн мэдээллийг өгөхгүй байх эрхтэй.

Кофе Шоп: Сургуулийн үүдний хэсэгт Кофе Шоп байрласныг та бүхэн анзаарсан байх. Сургуулийн Кофе Шопоор зөвхөн эцэг эхчүүд, багш ажилчид болон ахлах 11,12-р ангийн сурагчид эцэг эхийн зөвшөөрөлтэй үйлчлүүлнэ. Та бүхэнд ямар нэгэн санал хүсэлт байвал бид дуртайяа хүлээн авах болно. ОУДС нь хүрээлэн байгаа орчноо анхаардаг тул та бүхнийг авч явах кофе, цайндаа аль болох нэг удаагийн аяга хэрэглэлгүй, өөрийн аягыг авчирч үйлчлүүлбэл бид баярлах болно.

Сургууль дээрх хөнгөн зууш: Сурагчид өглөөнийхөө хөнгөн зуушийг сургууль дээрээ авчирч идэж болох бөгөөд сургуулийн эрүүл хооллох хэвшлийг төлөвшүүлэх үйл ажиллагааны дагуу бид хөнгөн зуушинд жимс, хүнсний ногоог санал болгодог. Уух зүйлс /ус байвал сайн/ -ийг шилэн бус хагардаггүй саванд хийсэн байх ёстой. Хийжүүлсэн ундаа, шоколад, чихрийг хөнгөн зуушинд хэрэглүүлэхгүй байхыг хүсье.

Эцэг эх, сурагчийн гарын авлага

Ангид төрсөн өдрийн баяр тэмдэглэх: Бага ангийн сурагчид хэрэв өөрөө хүсвэл төрсөн өдрөөрөө ангийнхантайгаа хуваалцах ЖИЖИГ ЗҮЙЛС -ийг сургууль дээрээ авчирч болно. Гадны үйлчилгээний байгууллагаас хүргэгддэг пицца, бэлэг, тоглоом гэх мэт зүйлс нь үүнд тохиромжгүй. Хувийн үйл ажиллагаа, үдэшлэгийн урилга нь анги хамт олонг бүхэлд нь хамруулах эсвэл сургуулиас гадуур хувийн журмаар тараагдах шаардлагатай.

ОУДС САМАРГУЙ ОРЧИН. Самарны хурц хэлбэрийн харшилтай сурагчид, багш ажилчдын тоо өсөн нэмэгдэж байгаа тул сургуулийн орчинд, сурагчдын автобусанд, сургуультай холбоотой үйл ажиллагаанууд дээр самар болон самар орсон бүтээгдэхүүнийг хориглоно.

Сургууль, багш, эцэг эхийн харилцаа холбоо

ОУДС болон эцэг эхчүүд хоорондын харилцаа холбоо нь тодорхой, ойлгомжтой, хурдан шуурхай байх нь хамгийн чухал зүйл мөн.

Харин бага сургуулийн хувьд **сурагчдын өдрийн тэмдэглэл** (The Student Planner) нь эцэг эх, багш нарыг холбох чухал хэрэгсэл болдог. Бага ангийн сурагчдын эцэг эхчүүд хүүхдийнхээ өдрийн тэмдэглэлтэй өдөр тутам танилцаж байх нь зүйтэй. Мөн багш нартай сургуулийн цахим шуудан болон утсаар холбогдох боломжтой. Туршлагаас харахад эцэг эх, багш нар өдөр тутмын, түр зуурын асуудлыг имэйлээр, мессэжээр шийдэх нь илүү тохиромжтой ч харин ярилцаж шийдвэрлэх шаардлагатай анхаарал татсан асуудлыг утсаар болон биечлэн уулзаж зохицуулах нь үр дүнтэй.

ОУДС -ийн вэбсайт нь мэдээллийг түгээх, дамжуулах төрөл бүрийн мэдээллийн холбоостой. Тус сургуулийн вэбсайт болон долоо хоног тутмын мэдээг www.isumongolia.edu.mn хаягаар орж үзнэ үү.

Бид чухал мэдээллүүдийг ОУДС-ийн Монгол эцэг эхчүүдэд зориулан монгол хэлнээ орчуулан байршуулах талаар анхаарч ажиллаж байна.

Сурагчдын сурах арга барилд дэмжлэг үзүүлэх тусгай үйлчилгээ

Counselor буюу Зөвлөх багш нь ОУДС-ийн багш нарын үндсэн бүрэлдэхүүний нэг бөгөөд сургуулийн бүх сурагчдад зөвлөгөө өгч, тусалж дэмжих үүрэгтэй. Зөвлөх багштай урьдчилан цаг товлож, боломжтой бол шууд уулзаж болно. Эцэг эхчүүд та бүхэнд хүүхэдтэй чинь холбоотой сэтгэл зовоосон асуудал байгаа бол **сургуулийн холбогдох удирдлага эсвэл Зөвлөх багштай холбогдохыг зөвлөж байна.** Учир нь Зөвлөх багшийн үзүүлэх зөвлөгөө тусламж нь хүүхдэд илүү өгөөжтэй байдаг.

ОУДС-ийн багш нарын үндсэн бүрэлдэхүүнд **Тусгай хэрэгцээт боловсролын мэргэжилтнүүд** багтах бөгөөд бага, дунд сургууль тус бүрд нэг нэг ажилладаг. Эдгээр мэргэжилтнүүд нэмэлт дэмжлэг шаардлагатай сурагчдад заавар зөвлөгөө өгч, удирдан чиглүүлж, багш нар, боловсролын туслахуудтай нягт хамтран ажилладаг.

Эцэг эх, сурагчийн гарын авлага

Түүнчлэн ОУДС-д бусад Олон улсын сургуулиудын нэгэн адил хэлний чадварын хувьд нэмэлт тусламж шаардлагатай сурагчдад дэмжлэг үзүүлэх Англи хэлний багш нар ажилладаг юм. Эдгээр багш нар тухайн сурагчид хэлний нэмэлт тусламж үзүүлж энэ талаар сургуулийн удирдлага, багш, хөтөлбөрийн зохицуулагч нартай хамтран ажилладаг.

Бага болон дунд сургуулийн түвшинд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг Сурагчдыг дэмжих баг /SST/ нь тогтмол уулзаж, дэмжлэг шаардлагатай байгаа сурагчдад тохирох хамгийн зөв арга зам юу болох талаар ярилцдаг. Зөвлөх багш, Тусгай хэрэгцээт боловсролын мэргэжилтэн, Англи хэлний багш нар болон сургуулийн удирдлагууд оролцох уг хурлаар тухайн арга зам нь тухайн сурагч нэг бүрд таарч тохирох талаар зөвшилцдөг.

Номын сан, сургалтын материалын төв /LRC/

ОУДС - ийн Номын сан нь хэвлэмэл болон хэвлэмэл бус материал, ном товхимолоор дамжуулан хувь хүн янз бүрийн санаа бодлыг таньж мэдэх боловсрол, соёлын орчин юм. Энэ төв нь хүүхдийн насан туршид хэрэглэгдэх мэдээлэл цуглуулж суралцах чадварыг болон унших дур сонирхлыг нь хөгжүүлэх үйл явцыг дэмжин ажилладаг. Номын сан нь суралцах нөхцөл бололцоог өргөжүүлэн тэлж, сургалт судалгааны ном сурах бичиг, бусад материалаар хангаад зогсохгүй мэдээлэл, эхийг боловсруулах чадвар олгох, үнэлэх дүгнэх өөрийн гэсэн хөтөлбөр хэрэгжүүлдэг.

Сурагчид номын сангийн биеэ даасан, хариуцлагатай хэрэглэгчид байна. Дунд сургуулийн сурагчид сургууль дээр ашиглах зорилгоор номын сангаас зөөврийн компьютер болон iPad авч хэрэглэж болно. Хэрвээ сурагч Номын сангаас авсан төхөөрөмжийг гэсэн, эвдсэн тохиолдолд зохих төлбөрийг эцэг эх төлж барагдуулна гэдгийг анхаарна уу.

Бичгийн хэрэгсэл / Сурах бичиг ашиглах журам / Тооны машин

Сурагчдын бичгийн хэрэгслийг сургуулиас хангана. Дунд сургуулийн сурагчдын сурах бичгийг сургуулиас олгох бөгөөд сурагчид сурах бичгүүдийг гамтай цэвэр хэрэглэн номын санд буцаан өгөх шаардлагатай. Тухайн сурах бичгийг хайр гамгүй эдэлсэн, хаяж гээгдүүлсэн бол тус сурах бичгийг шинээр худалдан авах нийт зардлыг төлнө.

Зарим нэг хичээлд тооны машин чухал хэрэгтэй байдаг. 9-12-р ангийн сурагчид өөрсдийн тооны машинаа авчрах хэрэгтэй. ОУДС -нь тухайн хичээлд тохиромжтой тооны машиныг нэгдсэн байдлаар захиалж өгч болно.

Сурагчдын танилцах аялал

Сурагчдын танилцах аялал бол хичээлийн хөтөлбөрийн нэг хэсэг юм. Сурагчид хичээлийн өдрөөр Улаанбаатар хот болон хотын ойролцоох газар, тэнд болох үйл ажиллагааг үзэж сонирхдог. Ямар ч тохиолдолд сурагчид аялалд оролцохоосоо өмнө эцэг эхийн гарын үсгээ зурж баталгаажуулсан зөвшөөрлийн хуудсыг багшид өгснөөр уг аялалд оролцох эрхтэй болдог. Аялалд явахдаа тохиромжтой гутал хувцас, хэрэгсэл, усны сав авч явна.

Эцэг эх, сурагчийн гарын авлага

Танхимын бүс сургалт

Сурагчдын сурах үйл ажиллагаанд өөрөө биечлэн, тогтмол идэвхтэй оролцож байж олж авсан, эзэмшсэн чухал хэрэгтэй үзэл бодол, чадвар, хандлагыг нь **дадлага туршлагаар эзэмшсэн мэдлэг боловсрол** гэнэ.

Олон Улсын Бакалавриат хөтөлбөр нь жинхэнэ утгаараа дадлага туршлага дээр үндэслэгдсэн сурах үйл ажиллагаа юм.

ОУДС нь дадлага туршлагаар мэдлэг чадвар төлөвшүүлэх үйл ажиллагааны хэлбэр болох сургуулиас гадуурх боловсролын, үйлчилгээний мөн нийгмийн харилцааны олон янзын төсөл арга хэмжээнд оролцох боломжийг сурагчиддаа олгодог.

Бага сургуулийн хувьд, сурагчид тэдгээрийн эрдэм мэдлэгийг тэлэх төрөл бүрийн үйл ажиллагаанд оролцдог. Эдгээрийн нэг нь танилцах аялал юм. Танилцах аялал нь цэцэрлэгийн ангиас 5 хүртэлх бүх ангийг хамран хичээлийн жилийн турш зохион байгуулагдана. 3, 4, 5-р ангийн сурагчид хичээлийн жилийн сүүлээр хоногоор аялалд явдаг.

Дунд сургуулийн хувьд, сурагчид дунд сургуулийн хөтөлбөрийн Олон нийт-Үйлчлэлийн программ (Service as Action), Дипломын хөтөлбөрийн CAS буюу Бүтээлч байдал, Үйл хэрэг, Үйлчилгээ программуудын хүрээнд хичээлийн жилийн эхээр бүх сурагчид багш нартайгаа зуслангийн аялалд явж, YACs буюу Залуу Адал Явдал Сонирхогчдын Клубт оролцдог.

Round Square IDEALS Долоо хоног: Хичээлийн жилийн эхэнд дунд сургуулийн сурагчид хариуцсан багш нарын хамт долоо хоногийн аялалд явдаг. Энэхүү аялалыг IDEALS долоо хоног гэж нэрлэдэг. Долоо хоногийн аялал нь сурагчдын хувьд Монгол орны байгаль орчин, түүх, соёлын талаар суралцах таатай боломж бөгөөд олж авсан мэдлэг туршлагаа хичээлүүдтэйгээ уялдуулан бүтэн жилийн туршид суралцдаг.

Багш -эцэг эхийн бүлэг /PTG/

Идэвхтэй үйл ажиллагаа бүхий багш-эцэг эхийн бүлэг нь нийт сургуулийн хамт олныг дэмжиж ажилладаг. Сургуулийн хамт олны гишүүд Багш - эцэг эхийн бүлгийн ивээн тэтгэсэн үйл ажиллагаанд нэгдэж оролцох бүрэн боломжтой. Багш Эцэг Эхийн Бүлэгтэй холбогдохыг хүсвэл ptg@isumongolia.edu.mn хаягаар холбогдоорой. Багш Эцэг Эхчүүдийн бүлэгт оролцохыг хүссэн эцэг эхчүүдтэй дуртайяа холбогдон хамтарч ажиллах болно.

Багш - эцэг эхийн бүлэг нь эцэг эхчүүдийг бүлгийн үйл ажиллагаанд тогтмол, идэвхтэй оролцохыг хүсдэг. ОУДС-ийн зүгээс эцэг эх, ажилтан, албан хаагч бүрийг Багш-эцэг эхийн бүлэгт нэгдэж, боломжтой бол үйл ажиллагаа зохион байгуулах бүрэлдэхүүн хэсэгт багтаж ажиллах талаар бодолцож үзэхийг танд санал болгож байна. Энэ бүлгийн хурал сард нэг удаа зохион байгуулагддаг.

Энэ талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тус сургуулийн вэбсайтын PTG хэсгээс үзнэ үү.

Эцэг эх, сурагчийн гарын авлага

Эцэг эхийн сайн дурын оролцоо

Бага сургуулийн багш нар эцэг эхчүүдийн ангид туслах, хүүхдийг уншуулах, танилцах аялалд хамтран оролцох зэрэг сайн дурын оролцоог таатай хүлээж авдаг. Хэрэв та бүхэн сургууль, хичээлийн үйл ажиллагаанд тусалж дэмжин оролцохыг хүсвэл хүүхдийнхээ ангийн багшид мэдэгдээрэй.

Бага сургуулийн хичээлийн хөтөлбөр: Цэцэрлэгийн ангиас 5-р анги хүртэл

ОУДС -ийн бага сургуулийн хичээлийн хөтөлбөр нь цэцэрлэгийн ангиас 5 хүртэлх ангийн сурагчдад тохирсон, тэдний хичээл чармайлтыг гаргахуйц, тусгайлсан үр нөлөө бүхий программ юм. Бага сургуулийн хөтөлбөрийг боловсруулахдаа судлагдахуун нь өргөн хүрээтэй, ихийг багтаасан байх зарчмыг баримталсан юм.

Олон Улсын Бакалавриат Түвшний сургалтын хувьд:

- Бүх сурагчид өөрсдийн бүхий л хүч, чармайлтыг дайчлан сургалтын үйл ажиллагаанд оролцох боломжоор хангагдсан байх
- Сургуулийн сургалтын хөтөлбөрт танхимын болон танхимын бус бүх л үйл ажиллагаа багтана. Эдгээр нь бүхэлдээ сурагчийн сурах арга барилд нөлөөлдөг учраас сургууль энэ бүх ажиллагааг хариуцан ажиллана.

Түлхүүр зарчим (Key concept):

Бага сургуулийн хичээлийн хөтөлбөрт 8 түлхүүр зарчим байх бөгөөд энэ нь тухайн сэдэв, хичээлийн хөтөлбөрийг боловсруулахад зохицуулах гол үүрэгтэй.

Түлхүүр зарчмууд

- Хэв маяг
- Өөрчлөлт
- Үүрэг хариуцлага
- Үйл ажиллагаа
- Харилцаа холбоо
- Эргэцүүлэл
- Учир шалтгаан
- Үзэл бодол

Хичээлийн хөтөлбөрийн гол цөм болсон эдгээр зарчмууд нь хичээлийн түлхүүр асуултад тусгагдсан байна. Уг түлхүүр асуулт бол асуудал дэвшүүлж судлан шинжлэх судалгаанд суурилсан хичээлийн гол удирдамж болж өгдөг.

Судлан шинжлэх замаар суралцах гэдэг нь Бага сургуулийн хөтөлбөр дэх сурагчийн танин мэдэх, сурах гол хэлбэр юм.

- Дээрх зарчмууд нь багш, сурагчдын чөлөөтэй сэтгэн бодох боломжийг нээн, цаашид урган гарах асуултаудыг чиглүүлэн, судлан шинжлэх үйл ажиллагааг бүтээлчээр хөтлөх түлхүүр болдог.
- Дээрх зарчмууд нь сурагчдад хэрхэн яаж судлах шинжлэх сэдлийг төрүүлж залж өгдөг түлхүүр болдог.

Эцэг эх, сурагчийн гарын авлага

Тавдугаар анги

Exhibition буюу мэдлэг чадварын үзэсгэлэн

5 дугаар ангийн сурагчдын мэдлэг чадварын үзэсгэлэн нь бага сургуулийн сурагчдын хувьд маш чухал ач холбогдолтой, хөтөлбөрийн амин чухал элементүүдийг нэгтгэн сургуулийн бүхий л хүрээлэлд дэлгэн харуулсан үйл ажиллагаа юм.

Энэ үзэсгэлэн нь Бага сургуулийн хөтөлбөрийн төгсгөлийн үйл ажиллагаа болохын хувьд уг хөтөлбөрийн хүрээнд олгогдох “**Сурагчийн эрхэмлэх зан чанар**”-ууд сурагчдад хэрхэн төлөвшсөнийг олж харах боломжийг бидэнд өгдөг.

Үзэсгэлэнгийн хүрээнд сурагчийн судлан шинжлэх сэдэв нь ямарч байж болох бөгөөд хөтөлбөрийн удирдагчдын саналаар шийдвэрлэгдэж болно. Энэ үед сурагчид танин мэдэж тодорхойлох, хянан шалгах, боломжтой арга замыг гаргаж ирэх зэргээр задлан шинжлэх үйл ажиллагаанд идэвхтэй хандах үүрэгтэй болдог.

Дунд сургуулийн хичээлийн хөтөлбөр: 6-10 -р анги

Энэ хөтөлбөр нь 11-16 насны сурагчдад зориулагдсан, тэднийг бүтээлч, нэгтгэн дүгнэж, эргэцүүлэн бодогч болгохыг дэмжсэн сурах үйл ажиллагаагаар хангадаг.

Тус хөтөлбөр нь оюуны хүч сорихыг чухалчлан анхаардаг бөгөөд сурагчдын хичээлээр сурсан мэдсэнээ бодит амьдралтай холбон хэрэгжүүлэхэд чухал ач холбогдол өгдөг. Мөн дэлхийн хэмжээний манлайлагч болох залуу хүмүүсийн гол чанар болсон харилцааны, олон үндэстний соёлыг ойлгох чадварыг сурагчдад төлөвшүүлэхэд анхаардаг. Дунд сургуулийн хичээлийн хөтөлбөр нь бага сургуулийн хөтөлбөрт тусгагдсан мэдлэг, чадвар, зан төлөвт суурилан боловсруулагдсан бөгөөд сурагчдыг ОУБ -ийн диплом олгох хичээлүүдийг үзэхэд нь бэлтгэх юм.

Хөтөлбөр нь:

- Сурагчдын оюун ухаан, нийгэм, сэтгэл санааны болон бие махбодийн хөгжлийн сайн сайханд анхаарлаа хандуулдаг.
- Сурагчдад дэлхий ертөнц дээрх нарийн түвэгтэй зүйлсийн учрыг ойлгож ухамсарлан, зохицуулах боломжийг өгөхийн зэрэгцээ тэдэнд ирээдүйдээ хариуцлагатай ханддаг болгох үүднээс шаардлагатай чадвар, үзэл бодол хандлагыг төлөвшүүлдэг.
- Найман төрлийн хичээлээр дамжуулж өргөн цар хүрээтэй, гүн гүнзгий мэдлэг, ойлголтыг сурагчдад эзэмшүүлдэг.
- Өөрсдийн болон бусдын соёлыг ойлгодог байхыг нь дэмжих зорилгоор сурагчдад наад зах нь хоёр хэлийг судлах шаардлага тавьдаг.
- Сурагчдын олон нийт, нийгмийн үйлчилгээнд оролцох оролцоог хөхуулэн дэмждэг.
- Сурагчдын цаашдын боловсрол, байр суурь, амьдралын туршид суралцах үйл ажиллагаанд бэлтгэхэд нь тусладаг.

Дунд сургуулийн хичээлийн хөтөлбөрөөр Гадаад хэл, Хэл, Уран зохиол, Нийгмийн ухаан, Байгалийн шинжлэх ухаан, Математик, Урлаг, Биеийн тамир-Эрүүл мэнд, Дизайн-Технологи гэсэн найман төрлийн хичээл үзэж судална. Нэг хичээлийн жилийн туршид нэг төрлийн хичээлийг хамгийн багадаа 50 цаг үзэж судлах ёстой.

Эцэг эх, сурагчийн гарын авлага

Дунд сургуулийн хөтөлбөр нь сурагчдын өөрсдийн гэсэн бодол санааг төлөвшүүлж, өөрийгөө ойлгож мэдрэх мэдрэхүйг нэмэгдүүлэн, нийгэм олон нийтийн дундах хариуцлагыг өндөржүүлэхэд туслах зорилготой.

Дунд сургуулийн хөтөлбөр нь дараах алхмуудад анхаарлаа хандуулдаг.

Алхам 1. Хам сэдвийн хүрээнд сургах, сурах

Сурагчид суралцаж буй зүйл нь бодит, тэдний амьдрал, амьдарч буй ертөнцтэй нь холбоотой бол хамгийн сайн суралцдаг.

IV Дунд Сургуулийн Хөтөлбөр нь найман төрлийн хичээлийг

- Шударга ёс ба хувьсал хөгжил
- Даяаршил ба тогтвортой байдал
- Хувь хүний болон соёлын илэрхийлэл
- Шинжлэх ухаан, техникийн хувьсал
- Орон зай, цаг хугацааны баримжаа

- Ижил төстэй байдал, харьцаа холбоо гэсэн зургаан хам сэдвийн (global context) хүрээнд уялдуулан холбож судлана. Сурагчид дээрх хам сэдвийг судлах замаар хүн төрөлхтөн, олон нийтийн асуудлуудыг танин мэдэж, дэлхийн хэмжээнд сэтгэхийн утга учрыг олж мэддэг.

Алхам 2. Түлхүүр ухагдахуун (conceptual understanding)

Ухагдахуун (concept) гэдэг нь тухайн хичээл, бүлэг сэдвийн хүрээнд үзэж судлах зүйлийн хамгийн гол санаа нь юм. Дунд ангийн сурагчид хичээлийн түлхүүр ухагдахууны хүрээнд хувь хүн, нутаг дэвсгэр, дэлхийн хэмжээний ач холбогдол бүхий асуудлыг судлан шинжилж, мэдлэг чадвараа өргөнөөр ашиглан туршдаг.

Хичээлд хэрэгдэгдэх 16 түлхүүр ухагдахуун:

Гоо зүй	Өөрчлөлт	Харилцаа	Нийгэм
Холбоо хамаарал	Бүтээмж	Соёл	Хөгжил
Хэв маяг	Олон нийтийн харилцаа	Адил төст байдал	Уялдаа холбоо
Үзэл бодол	Нөхөрлөл	Тогтолцоо	Цаг хугацаа, байршил, орон зай

Алхам 3. Суралцах арга барил (Approaches to learning)

Дунд сургуулийн бүх хичээл сурагчдад сурах арга барил төлөвшүүлэхэд нэгдмэл байдлаар анхаардаг бөгөөд сурагчдын бие даан суралцах, шинэ нөхцөл байдалд мэдлэг чадвараа хэрхэн ашиглах суурийг нь тавьж өгдөг. Энэхүү суурь болсон чадварыг хөгжүүлж, хэрэгжүүлэх нь сурагчдад хэрхэн суралцах арга замыг сурч мэдэхэд тусалдаг байна. Дунд сургуулийн хөтөлбөрөөр олгох суурь чадваруудыг дараах 5 ангилалд багтаан олгодог. Үүнд: бодож тунгаах, өөрийгөө удирдах, судалгаа хийх, харилцах, нийгэмших буюу хамтран ажиллах ур чадвар.

Эцэг эх, сурагчийн гарын авлага

Алхам 4: Үйл хэрэг, үйлчлэл буюу нийгмийн үйлчлэл

Үйл хэрэг (хийж бүтээж, дадлага туршлагаар олж сурах үйл явц) ба үйлчлэл нь Олон улсын бакалавриат сургалтын нэгэн чухал үнэт зүйл байсаар ирсэн бөгөөд сурагчид хичээлээр болон хичээлээс гадуур олж авсан мэдлэг чадвараа үйл хэрэг болгон хэрэгжүүлдэг. ОУБ-н сурагч нь бусдын амьдралд, хүрээлэн буй орчиндоо эерэг өөрчлөлт авчрах үйлчилгээг үзүүлэгч, нийгмийн халамжтай гишүүн байхын төлөө хичээн чармайна. Олон нийт, нийгэмд үйлчлэх нь тус хөтөлбөрийн нэг салшгүй хэсэг юм.

Алхам 5: Хэл, ижил төстэй байдал

Дунд сургуулийн сурагчид дор хаяж 2 хэлийг сурч судлах шаардлагатай. Харилцааны олон хэлбэрийг сурч эзэмших нь сурагчдын олон үндэстний соёлын ойлголтыг хөгжүүлэх гол суурь төдийгүй өөрсдийн давуу чанараа олж мэдэхэд нь чухал ач холбогдолтой. ОУДС -ийн дунд сургуулийн хөтөлбөрт англи, монгол, солонгос хэлийг ХЭЛ-УРАН ЗОХИОЛ судлалын түвшинд үзэж судалдаг. Франц болон Мандарин (Хятад) хэлийг ГАДААД ХЭЛ судлалын хэмжээнд эзэмших боломжтой.

Алхам 6: Дунд сургуулийн хөтөлбөрийн БИЕ ДААЛТЫН АЖИЛ (Personal Project)

10-р ангийн бүх сурагчид дунд сургуулийн хөтөлбөрийн нэг хэсэг болох бие даалтын ажлыг хийдэг. Сурагчид уг ажлыг бие даан, бүтээлчээр хийж гүйцэтгэх бөгөөд үүгээр тэдний бие даан судалгаа шинжилгээ хийх, төсөл боловсруулж хэрэгжүүлэх чадварууд нэг цогц болж харагдах болно.

Дунд сургуулийн 11-12 -р ангийн хичээлийн хөтөлбөр

ОУБакалавриатын диплом олгох хөтөлбөрөөр 6 төрлийн хичээл үзэж судална. Диплом горилогч доорх 6 бүлэг хичээл тус бүрээс нэг хичээлийг сонгох ба 1-4-р бүлгээс сонгох хоёрдугаар хичээл нь 6-р бүлгийн хичээлийг орлож болно. Сонгосон хичээлийнхээ 3 эсвэл 4 хичээлийг ахисан түвшинд/HL/, харин бусад хичээлийг нь стандарт түвшинд /SL/ үзэж судлах болно.

Дээд түвшний хичээлийг багадаа 240 цаг үздэг бол стандарт түвшний хичээлийг 150 цаг судална. Иймд сурагчид зарим хичээлийг гүнзгийрүүлж, заримыг нь өргөн хүрээтэйгээр судалдаг.

1-р бүлэг. Хэл, уран зохиол судлал

ОУБ-ын хөтөлбөр нь сурагчдыг өөрсдийнх нь үндэсний соёлтой нь нягт холбоотой байлгахыг дэмждэг. Энэ сургалтын журмын дагуу 80 гаруй хэл дээр шалгалт авах боломжтой. Дэлхийн уран зохиол судлалаар сурагчид төрөлх хэлнийхээ утга зохиолын өв уламжлалыг хүндэтгэх мэдлэг боловсролыг эзэмшээд зогсохгүй, төрөлх хэлний бичгийн болон ярианы өндөр ур чадварыг олж авдаг. 1-р бүлгийн хичээлд англи, монгол, солонгос хэл судлалын хичээлүүд багтдаг.

2-р бүлэг. Гадаад хэл

Бүх диплом горилогч сурагчид нь хоёрдогч хэлээр шалгалт өгдөг. Гадаад хэлний шалгалт нь хоёр хэлийг өндөр түвшинд эзэмшсэн, тухайн хэлийг өмнө сурч судалж байсан, эхлэн суралцагч нарт зориулсан зэрэг хэд хэдэн боломж нөхцөлтэй байна.

Эцэг эх, сурагчийн гарын авлага

Сурагчид тухайн гадаад хэлийг төрөл бүрийн нөхцөл байдалд, өөр өөр зорилгоор ашиглаж сурах нь 2 дугаар бүлэг хичээлийн гол зорилго бөгөөд сурагчдын бичгийн болон аман харилцаанд голчлон анхаардаг. 2-р бүлэг хичээлд Хятад, Англи, Испани болон Франц хэлний хичээл багтана.

3-р бүлэг. Нийгмийн ухаан

Энэ бүлэгт Бизнес-менежмент, Эдийн засаг, Түүхийн хичээлүүд багтана. Тухайн сурагч эдгээр хичээл тус бүрийг ахисан эсвэл стандарт түвшинд судалж болно. Энэ хичээлүүдийг судалснаар сурагчийн хүн төрөлхтний туршлага, төлөв байдал, түүх соёлын нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгөх чадвар хөгжихийн зэрэгцээ эдийн засаг, нийгмийн төрөл бүрийн хүрээлэлд хүндэтгэлтэй хандах хандлага нэмэгдэх болно.

Түүнчлэн энэ бүлгийн хичээл нэг бүр сурагчдын нийгэм, хувь хүний үйл ажиллагаа, байгальтай холбоотой зарчим, онол, дүгнэлтүүдийг эргэцүүлэн дүн шинжилгээ хийх, тодорхойлох чадавхийг хөгжүүлэх зорилготой байдаг.

4-р бүлэг. Байгалийн шинжлэх ухаан

4-р бүлэгт Биологи, Хими, Физикийн хичээлүүд багтах бөгөөд ахисан болон стандарт аль ч түвшинд судалж болно. Энэ хичээлүүдээр сурагчид хэсэг бүлгээр ажиллан хамтран суралцах чадвараа нэмэгдүүлэхийн зэрэгцээ лабораторийн туршилт хийх чадвараа хөгжүүлдэг. Мөн сурагчдын ёс суртахуун, ёс зүйн талаарх мэдлэг ойлголт өргөжин, улс үндэстэн, дэлхий нийтэд тулгамдсан асуудлыг авч үзэн эргэцүүлэх чадвар хөгжиж, нийгэмд хүлээх хариуцлагыг мэдрэх мэдрэмж нь нэмэгдэх болно.

5-р бүлэг. Математик

Диплом горилогч бүх сурагчид математикийн хичээл үзсэн байх шаардлагатай ба сурагчдын сонирхол, чадварыг харгалзан Математик судлал, Стандарт түвшин, Ахисан түвшин гэсэн гурван түвшинд энэ хичээлийг заадаг. Түвшин бүр сурагчдын математикийн мэдлэгийг гүнзгийрүүлэх, математикийн хэлийг ойлгож мэддэг, нөхцөл байдалд тохируулж итгэлтэйгээр ашиглах чадвартай болгоход чиглэгдэнэ.

6-р бүлэг. Урлаг

Энэ бүлэгт дүрслэх урлагийн хичээл багтах бөгөөд сурагчид дэлхий нийтийн төрөл бүрийн урлагийн бүтээлтэй танилцахын сацуу өөрсдийн гэсэн бүтээлийг урлах болно. Сурагч энэ хичээлд сонирхолгүй бол 4-р бүлгийн хичээлээс хими, 3-р бүлгээс эдийн засаг гэх мэт бусад бүлгийн тодорхой хичээлийг оронд нь сонгон үзэж болдог.

Бүтээлч байдал, үйл ажиллагаа, үйлчилгээ

ОУБ (Олон Улсын Бакалавриат)-ын байгууллагын гол зорилго бол хүнийг бүхэлд нь хөгжүүлэх, хариуцлагатай, энэрэнгүй иргэнийг дэмжих юм. Энэхүү хөтөлбөр нь сурагчдын эрч хүч, онцгой авьяас чадвараа бусадтайгаа хуваалцахыг хөхүүлэн дэмждэг. Тухайлбал сурагчид театр, хөгжим, спорт, нийгмийн үйлчилгээнд сайн дураараа оролцож болох юм. Эдгээр үйл ажиллагаанд оролцсоноор сурагчид өөрсдийгөө танин мэдэж, бусдыг анхаарч, бусадтай бүтээлчээр хамтран ажиллах чадвараа хөгжүүлдэг.

Бие даасан исээ

Сурагч бүр өөрийн тусгайлан сонирхсон сэдвийн дагуу судалгаа хийн исээ бичдэг. Сурагчид исээ бичсэнээр судалгаа шинжилгээ хийх, бичих чадвараа сайжруулах зэрэг их сургуульд шаардлагатай чадваруудаа сайжруулдаг. ОУБ-ын хөтөлбөрийн дагуу сурагч 40 орчим цагийг бие даан суралцах, исээ бичихэд зориулах шаардлагатай байдаг. Энэ исээ нь 60 гаруй төрлийн хичээл - судлагдахууны аль нэгийг хамарсан, дэлхийн олон хэлний аль нэгээр бичигдсэн байна. Бие даан исээ бичих нь сурагчдыг сургалтын хөтөлбөрийг гүнзгийрүүлэн судлахад хүргэдэг. Жишээлбэл: Ахисан түвшний нэг курсэд үздэг сэдвийг сонгох эсвэл сонгосон хичээлийн хөтөлбөрт багтаагүй ухагдахууны хүрээнд исээ бичихээр сонгох нь тэдний сурлагын амжилтыг нэмэгдүүлнэ.

ОУДСургуулийн хэлний сургалт

ОУДСургууль нь хэлийг эзэмших үйл явцыг сургах, сурах үйл ажиллагааны бүхий л талыг хамарсан насан туршийн боловсрол гэж үздэг. Энэ нь сурагчийн хувийн онцлог чанарыг хөгжүүлж, соёл хоорондын тухай ойлголтыг нэмэгдүүлэн, үзэл бодлоо чөлөөтэйгээр илэрхийлэх боломжийг олгодог.

Судалгаанаас үзэхэд тухайн хүний эх хэлний мэдлэгийн түвшин нь хоёрдогч болон бусад гадаад хэлийг амжилттай сурахад нь шууд нөлөөлдөг байна. Тиймээс бид сурагчдын эх хэлний мэдлэгийн түвшинг сайжруулж хөгжүүлснээр тэдний өөрийн хувийн онцлог чанар, үнэлэмж, сурлагын амжилтыг улам бүр бататгаж өгнө гэдэгт итгэдэг.

Англи хэлний сургалт

ОУДС-н сургалт Англи хэл дээр явагдана. Сурагчид зохих түвшний англи хэлний мэдлэгтэй байх нь тэднийг сургуулийн бүх л хөтөлбөрийг амжилттай судлахад чухал нөлөөтэй. ОУДС-д элсэх сурагчдыг зохих түвшний англи хэлний мэдлэгтэй байхыг шаарддаг хэдий ч Англи хэлний нэмэлт хичээл (EAL) хэрэгтэй зарим сурагчид байдаг. Англи хэлний нэмэлт сургалтад бага, дунд сургуулийн сурагчид хамрагдах боломжтой.

ОУДСургуулийн хэлний хөтөлбөрийн товч танилцуулга

ОУДС-ийн сурагчид нь суралцаж буй хугацаандаа Англи хэлнээс гадна өөр нэг хэлийг сонгон суралцах шаардлагатай. Энэ хэл нь сурагчийн төрөлх хэл, өмнө нь эзэмшиж хэрэглэж байсан эсвэл шинээр сурах хэл байж болно.

Бага, дунд сургуулийн бүх ангийн сурагчид англи хэлийг үзэх шаардлагатай. Сурагчдад англи хэлний нэмэлт хичээлийг Англи хэлний мэргэжилтэн багш тусгайлан заах бөгөөд төрөл бүрийн хичээлийн сэдвийн хүрээнд хичээлийн болон хичээлийн дараа цагаар, ганцаарчлан заах гэх мэт янз бүрийн арга замаар дэмжлэг үзүүлдэг.

Эх хэл судлалын хувьд Монгол сурагчид цэцэрлэгээс 6-р ангид Монгол хэлээ эх хэлний түвшинд өргөжүүлэн судална. Харин 7-р ангиас Монгол, Франц, Хятад хэлний аль нэгийг сонгон сурах боломжтой.

Мөн Солонгос сурагчид 6-р ангид Солонгос хэлээ үзэж судална. 7-р ангиас Солонгос, Франц, Хятад хэлний аль нэгийг сонгон сурах боломжтой.

ОУДС нь монгол болон солонгос эх хэлтэй сурагчдын эх хэлний мэдлэгийг нэмэгдүүлэх, мөн олон улсын бакалавриатын диплом хамгаалах курсын гол суурь гүйцэтгэл болох 2 хэлний диплом авах шаардлагыг хангахад ихээхэн анхаардаг.

Эцэг эх, сурагчийн гарын авлага

Бусад сурагчдын хувьд 6-12-р ангидаа Хятад эсвэл Франц гэсэн хичээлийг хоёрдогч хэлээр сонгон суралцана.

ОУДС -д 10-р ангидаа элссэн, хятад, франц хэлний алийг ч сурч байгаагүй сурагчид өмнөх хоёрдогч хэлээ эсвэл эх хэлээ үргэлжлүүлэн судлах онлайн хэлний сургалтаар, эсвэл ганцаарчилж заах багштай, өөрийн төлбөрөөр ОУДС дээр суралцах боломжтой. Мөн 11, 12 дугаар ангиас Испани хэлийг эхлэн сурч болно.

Төрөлх хэл нь англи хэл биш тохиолдолд Дипломын түвшний сурагчид 11-12-р ангид өөрсдийн эх хэлээ бие даан үзэх боломжтой.

Монгол хэл А болон Монгол хэл В түвшний хичээл

Монгол хэлийг эх хэлний түвшинд судлах хичээлийг Монгол хэл А, гадаад хэлний түвшинд үзэж судлах хичээлийг Монгол хэл В хичээл гэж нэрлэж авч үздэг.

ОУДС нь оршин буй Монгол улсынхаа хэл, соёлыг өндрөөр үнэлдэг. Эх хэл нь Монгол бус сурагчид цэцэрлэгийн наснаас 6-р анги хүртэл монгол хэлийг гадаад хэлний хэмжээнд анхан, дунд шатны түвшинд үзэж судалдаг.

6-р ангид элсэн орж буй бүх сурагчид хоёрдогч хэл үзэх ёстой бөгөөд Монгол эсвэл Солонгос эх хэлтэй сурагчид өөрсдийн эх хэлээ үзнэ. Харин бусад сурагчид Хятад болон Франц хэлнээс сонгож судална.

Номын сангийн хэлний сургалтанд үзүүлэх нөлөө

Тус сургууль нь хэл сурахад болон сурлагын амжилтанд бүх талаар дэмжлэг үзүүлэх баялаг ном сурах бичиг, сургалтын материал бүхий сурах орчинг бүрдүүлэхийг чухалд авч үздэг. Анги танхимаар болон хичээлээс гадуур ашиглах хэвлэмэл, хэвлэмэл бус сургалтын материалын бүрдлийг сайжруулах нь сурагчдын сурах үйл ажиллагааг эрчимжүүлэх, сурлагын амжилтад сайнаар нөлөөлөх чухал ач холбогдолтой байдаг. ОУДС-ийн номын сан нь хэл сурах үйл ажиллагаанд чухал үүрэгтэй оролцож, англи, монгол, солонгос, франц, испани болон бусад хэл дээрх ном сурах бичиг, сургалтын материалаар баяжигдсаар байдаг. Номын сан нь бүлэг хичээлүүдийн хам сэдэвт суурилан утга зохиолын чадварыг сурагчдад олгох тусгай хөтөлбөр хэрэгжүүлэн ажилладаг.

Хэл сурахад эцэг эхийн үүрэг

Сурагчийн хэл сурахад эцэг эхийн үүрэг оролцоо чухал байдаг. Эцэг эх та бүхэн гэртээ байхдаа ч хүүхдийнхээ эх хэлийг болон сургууль дээр судалж сурч буй хэлний зөв хэрэглээг дэмжин хэл сурах үйл явцад нь түлхэц үзүүлж байх хэрэгтэй.

Тиймээс эцэг эхчүүд:

- Шинээр хэл сурах нь ямарч насны хүнд хичээл зүтгэл шаардах, бас гайхамшигтай зүйл байдаг гэдгийг хүүхэддээ ойлгуулах
- Хүүхэдтэйгээ тогтмол эх хэлээрээ харьцаж байх
- Хүүхдийг өдөр бүр англи хэлээр ярих боломжоор хангаж байх хэрэгтэй байдаг.

Зөв бичих чадвар

ОУДС нь Америк болон Англи хэлний зөв бичгийн дүрмийн аль алийг даган баримталдаг.

Сурагчийг үнэлэх, дүгнэх, тайлагнах

Мэдлэгийг үнэлэх, дүгнэх

ОУДСургууль нь сурагчдыг Олон Улсын Бакалавриатын хөтөлбөрийн үнэлгээний зарчмын дагуу дүгнэдэг. ОУДС-ийн баримтлах үнэлгээний зарчим дараах 3 зүйл философи дээр тулгуурлана. Үүнд:

- Суралцах үйл явц суралцагчаас идэвхтэй оролцоог шаарддаг.
- Хүн бүр өөр өөр арга замаар, өөр өөр түвшинд суралцдаг.
- Суралцах үйл ажиллагаа нь хувь хүний болон хамтын, багийн үйл ажиллагаа байдаг.

ОУДС нь сурагчийн мэдлэгийг **түвшин тогтоох, хичээлийн явцын, нэгтгэн дүгнэх буюу эцсийн** гэсэн 3 байдлаар үнэлэн дүгнэдэг.

- **Түвшин тогтоох үнэлгээ:** Аливаа сургалт, бүлэг сэдэв судлахын өмнө сурагчдын суурь болон өмнөх мэдлэгийг шалган тодорхойлох хэрэгтэй болдог. Мөн энэ нь багшид сурагчдын цаашдын сурах үйл ажиллагааг өргөтгөх, идэвхижүүлэх арга замыг тодорхойлоход нь тусална. Энэ аргаар ОУДС-д шинээр элсэн орж буй сурагчдыг үнэлж дүгнэдэг.
- **Явцын үнэлгээ:** Энэхүү үнэлгээ нь сурах, сургах үйл явцыг сайжруулах зорилгоор хийгдэж буй үргэлжилсэн үйл явц юм. Явцын үнэлгээ нь сурагч, багш, эцэг эхчүүдэд тухайн сурагчийн сурах явцын талаар цаг тухайд нь мэдээлэх, цаашид илүү сайн сургахын тулд хэрхэн яах ёстойг дүгнэн цэгнэхэд чухал ач холбогдолтой.
- **Нэгтгэн дүгнэх буюу эцсийн үнэлгээ:** Энэ үнэлгээ нь бүлэг сэдэв судалж дууссаны дараа сурагчдын сурсан мэдсэнийг бататган дүгнэхэд хэрэглэгддэг бөгөөд мөн сурагчдын сурлагын амжилтыг тодорхойлдог.

Стандартчилагдсан болон ерөнхий үнэлгээ

ОУДС сурагчдын мэдлэг эзэмшсэн байдал, багшийн хичээл заах үйл ажиллагааг хянахдаа сургуулийн хэмжээнд стандартчилагдсан, ерөнхий үнэлгээг ашигладаг. Эдгээр үнэлгээг жилийн туршид үечилсэн байдлаар хийдэг. 3-10-р ангийн сурагчдын мэдлэгийн түвшин тогтоох шалгалт /MAP/-г намар, хаврын улиралд авдаг ба үнэлгээний дүнг тухайн үед нь эцэг эх сурагчдад мэдээлдэг. Харин сургуулийн өмнөх 5 наснаас 5-р анги хүртэлх сурагчдын унших чадварыг хичээлийн жилийн туршид шалгаж дүгнэдэг. Энэ талаарх дэлгэрэнгүй мэдээллийг ангийн багш нараас авч болно.

Дүнгийн ерөнхий тайлан

ОУДС хичээлийн жилийн эхэнд эцэг эхчүүдээс хүүхдийнх нь талаар мэдээлэл авах зорилгоор “Сонсох хурал” зохион байгуулдаг. Энэхүү хурлаар эцэг эхчүүд өөрсдийн хүүхдийн талаарх санал бодлоо багштай нь хуваалцаж, хичээлийн жилийн эхнээс сурагчдаа зөв таньж мэдэхэд багш бидэнд тусалдаг юм. Тус сургуулийн цахим хуудаснаас Сонсох хурлын товыг мэдэж болно.

ОУДС хичээлийн жилийн туршид тогтсон хугацаанд сурагчдын сурлагын амжилтыг эцэг эхэд нь цахим хуудсаар тайлагнадаг. Бүх тайлан ОУДС -ийн “ManageBac” цахим хуудсанд тавигддаг тул эцэг эх та бүхэн өөрийн цахим нэрээр нэвтрэн танилцах боломжтой. ОУДС нь тайланг хэвлэн тараадаггүй. Эцэг эх, сурагч, багш нар хамтдаа

Эцэг эх, сурагчийн гарын авлага

сурагч нэг бүрийн сурлагын амжилтын талаар Эцэг эх - багш нарын төлөвлөсөн хурал дээр уулзаж, хэлэлцэх боломжтой. Бүх сурагчид эцэг эхийн хамт энэ хуралд оролцоно. Энэхүү хурлын товгыг сургуулийн хуанлид тэмдэглэсэн байдаг. Сурагчид хичээлийн жилийн эхнээс л өөрсдийн сурсан мэдсэнээ бусдад тайлагнан харуулах зорилго бүхий тайлант хавтасыг (portfolio) бүрдүүлж эхэлдэг. Энэ хавтсанд сурагчдын өөрсдийнх нь хийсэн бүтээсэн ажлууд багтдаг.

ОУДС-ийн сурагчийн дүнгийн тайлангийн цахим хуулбар нь анги тус бүрийн файлд тусгаарлагдан хадгалагдана. Сурагчийн улирлын дүн нь 9-р ангиас эхлэн дунд сургуулийн дүнгийн гэрчилгээнд албан ёсоор тавигддаг. Дунд сургуулийн дүнгийн гэрчилгээ нь тухайн сурагч өөр сургууль руу шилжихэд мөн 12-р ангийн сурагчид цаашдаа их дээд сургуульд элсэхэд хэрэгтэй байдаг.

Таны хүүхдийн сурлагын тайлан нь ОУДС-ийн 8 болон түүнээс доошхи ангийн бүх сурагчдын хувьд албан ёсны баримт бичиг гэдгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Эдгээр баримт нь таны хүүхдийн цаашдын сурч боловсрох үйл явцад чухал тул хариуцлагатайгаар хадгална уу гэдгийг сануулахад илүүдэхгүй биз ээ.

Бага сургуулийн хөтөлбөрийн дүнгийн тайлан

Бага сургуулийн дүнг тайлагнах үйл ажиллагаа нь ОУБ-ын бага сургуулийн хөтөлбөрт тодорхойлогдсон журмын дагуу явагдана. Сурагчийг үнэлж дүгнэх нь багшийн болон сурагчийн өөрсдийн ажиглан, нэгтгэн дүгнэх идэвхитэй үйл ажиллагаа мөн. Энэхүү үнэлгээ нь сурагчид сургалтын үйл ажиллагааны явцад ямар үед юуг мэдэж, юуг ойлгож, юуг хийж чаддаг болсныг тодорхойлно. Энэ үнэлгээ дүнгийн мэдээллийг сурагч, эцэг эхчүүдэд тайлагнана.

Бүлэг сэдэв бүрийн төгсгөлд сурагчийн сурсан явцын талаар мэдээлдэг ба илүү тодорхой тайланг хичээлийн жилийн эцэст хүргэдэг.

Дунд сургуулийн хөтөлбөрийн дүнгийн тайлан

Дунд сургуулийн хувьд Гадаад хэл (Хятад, Франц), Хэл, Уран зохиол (Монгол, Англи, Солонгос), Нийгмийн ухаан, Байгалийн шинжлэх ухаан, Математик, Дүрслэх урлаг, Биеийн тамир-Эрүүл мэнд, Дизайн-Технологи гэсэн 8 бүлэг хичээлээр дүнгийн тайлан гардаг. Тухайн сурагч хичээл бүрд 1/хамгийн доод/-ээс 7/хамгийн өндөр/гэсэн дүнгээр үнэлэгдэнэ.

Тайланд гарах дүн нь тухайн сурагчийн тухайн анги түвшинд тогтвортой үзүүлсэн амжилтыг илэрхийлэхээс биш сурагчийн өмнөх дүнгүүдийн дундаж биш юм.

Дүнгийн тайланд сурлагын амжилтыг тайлагнахаас гадна харилцааны чадвар, хамтран ажиллах чадвар, хувийн зохион байгуулалт, судалгаа хийх чадвар, эргэцүүлэн бодох чадваруудыг багтаан сурах хандлага, ур чадварыг нь дүгнэн гаргадаг.

Хичээлийн жилийн хугацаанд нэгдүгээр улирлын явцын, эцсийн, хоёрдугаар улирлын явцын, эцсийн гэсэн 4 удаагийн дүнгийн тайлан гарна. Эцэг эхийн хурлыг тайлан бэлтгэгдэж гарснаас хойш нэг долоо хоногийн дараа хийнэ. Түүнчлэн жил бүрийн хавар бүх эцэг эх, сурагчид **сурагчийн өөрөө удирдах хуралд** оролцох шаардлагатай.

Эцэг эх, сурагчийн гарын авлага

Диплом олгох хөтөлбөрийн дүнгийн тайлан

11-12-р ангийн сурагчдын дүнгийн тайлан нь ОУБХ –ийн хичээлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийн дагуу бэлтгэгдэх бөгөөд хичээл бүр нь ялгаатай байдаг.

Хичээлийн жилийн хугацаанд нэгдүгээр улирлын явцын, эцсийн, хоёрдугаар улирлын явцын, эцсийн гэсэн 4 удаагийн дүнгийн тайлан гарна. Эцэг эхийн хурлыг дүнгийн тайлан гарснаас хойш (хоёрдугаар улирлын эцсийн тайлан хамаарахгүй) 7 хоногийн дараа зохион байгуулна. Бүх эцэг эх, сурагчид 4-р сард зохиогддог **Сурагчийн өөрөө удирдах хуралд** оролцох шаардлагатай.

Гэрийн даалгавар

Гэрийн даалгавар болгон тодорхой зорилготой. Сурагчид тухайн даалгаврын зорилгыг ойлгосон байх хэрэгтэй. ОУДС-с тодорхойлсноор, гэрийн даалгавар гэдэг нь тогтоосон хугацаанд сургуулиас гадуур хийж гүйцэтгэх шаардлагатай ажил юм. Гэрийн даалгавар нь төлөвлөн, зохион байгуулах чадварууд болоод бие даан суралцах дадлыг хөгжүүлэхэд чухал үүрэгтэй.

Үүрэг хариуцлага

Сурагчийн **гэрээр** амжилттай **суралцах** нь багш, сурагч, эцэг эх хоорондын хариуцлагатай хамтын ажиллагааг бий болгодог.

Тухайн хичээлийн багш нарын үүрэг хариуцлага:

- Сурагчид гэрийн даалгаврынхаа зорилгыг ойлгосон байх ёстой бөгөөд уг даалгавар нь сурч буй сэдэв зүйлтэй холбоотой байх.
- Гэрийн даалгаврыг бүлэг, хамт олноор эсвэл эцэг эхийн тусламжтайгаар хийж гүйцэтгэх эсэхийг тодорхой хэлж өгөх. Бусад үед гэрийн даалгаврыг сурагч ганцаар бие даан гүйцэтгэх ёстойг сануулах.
- Зарим гэрийн даалгавар нь тухайн сурагчийн судалж буй хичээл, сэдвүүдийн талаархи суурь мэдлэгийг нэмэгдүүлэх зорилготой байж болно.
- Залхаах, шийтгэх зорилгоор гэрийн даалгаврыг өгөхгүй байх.
- Сурагчдад шаардлагатай зөв зохистой зөвлөгөө, дүгнэлтийг цаг тухайд нь өгсөн байх.

Сурагчийн үүрэг хариуцлага:

- **Сурагчийн өдрийн тэмдэглэлд** гэрийн даалгавраа тэмдэглэдэг байх. Бага сургуулийн сурагчид тэмдэглэж авсан даалгавраа эцэг эхдээ танилцуулж, гарын үсгийг нь зуруулсан байх.
- Гэрийн даалгавраа өөрсдийн боломжийг дайчлан, заасан хугацаанд хийж гүйцэтгэх.
- Хэрэв сурагч ямар нэг шалтгаанаар гэрийн даалгавраа заасан хугацаанд хийж чадахааргүй тохиолдолд ангийн багшдаа урьдчилан мэдэгдэх.

Эцэг эхийн үүрэг, хариуцлага:

- Хүүхдийн суралцах, ажиллах таатай орчныг бүрдүүлэх.
- Гэрийн даалгавартай холбоотой ямар нэгэн асуудал гарсан тохиолдолд багш нартай холбогдох.

Эцэг эх, сурагчийн гарын авлага

- Сурагчийн бие даан сурах ур чадварыг хөгжүүлэхэд туслах.
- Бие даан судалгаа шинжилгээ хийхэд шаардлагатай компьютер, принтер, интернетээр хангах.

Бага ангийн сурагчдын гэрийн даалгавар

Сурагчдын бие даан гэрийн даалгавар гүйцэтгэх хугацаа:

- Цэцэрлэг - 1-р анги өдөрт 15-20 минут
- 2-3-р анги өдөрт 30-45 минут
- 4-5-р анги өдөрт 45минутаас - нэг цаг

Гэрээр унших: Гэрийн даалгавраас гадна өдөр бүр ном унших дадлыг сурагч бүрт хэвшүүлэх шаардлагатай.

Бага ангийн сурагчдыг гэрээр уншуулах зарим арга барил:

1. Номон дээрх зургуудыг харж ярилцах. Энэ арга нь анхлан уншиж сурж байгаа хүүхдүүдэд их чухал ач холбогдолтой.
2. Юуны тухай унших гэж байгаагаа урьдчилан таамаглан ярилцах.
3. Уншиж буй зүйлийнх нь утгыг ойлгоход хүүхэддээ туслах. Үг, өгүүлбэр бүрийг ойлгож байгаа эсэхийг анхаарч, үйл явдлыг нь өөрийнх нь үгээр яриулах.
4. Хүүхдээсээ тухайн номын дүрүүд, үйл явдал, үйл явдал өрнөх газрын талаар асуух.
5. Хүүхдийнхээ унших бүрт нь урам өгөн дэмжих.
6. Унших нь хүүхдэд байнга тааламжтай сэтгэгдэл түрүүлж байх хэрэгтэй. Унших үйл явцыг хөгжилтэй байлгаарай.

Дунд сургуулийн сурагчдын гэрийн даалгавар: (Дунд болон дипломын хөтөлбөр)

Гэрийн даалгавар нь:

- Шинээр олж авсан чадвараа давтах, бататгах хэлбэрээр
- Хичээл дээр заасан зүйлийг өргөжүүлэх, үргэлжүүлэх хэлбэрээр
- Хичээлийн үйл ажиллагаанд сурагчдыг бэлтгэх хэлбэрээр
- Дипломын хөтөлбөрийн бие даасан исээ, Дунд сургуулийн хөтөлбөрийн бие даасан төсөл боловсруулах зэрэг тухайн хөтөлбөрөөс хамаарах исээ, курсийн ажил гэх мэт олон хэлбэрээр өгөгдөж болно.

Ангид хичээл дээр хийх ёстой даалгаврыг цаг тухайд нь дуусгаагүй тохиолдолд гэртээ үргэлжүүлэн хийж болох бөгөөд энэ нь гэрийн даалгавар гэхээс илүүтэйгээр ангийн ажлын үргэлжлэл гэж тооцогдоно.

Хугацаа:

Сурагчдын гэрийн даалгавар хийж дуусгах хугацаа нь харилцан адилгүй. Гэрийн даалгаврыг сурагч бие даан гүйцэтгэх хэрэгтэй. Бусад сурагчдын гэрийн даалгаврыг хуулах, эцэг эх, гэрийн багш сурагчийн өмнөөс гэрийн даалгаврыг нь хийхийг хүлээн

Эцэг эх, сурагчийн гарын авлага

зөвшөөрөхгүй. Ингэсэн тохиолдолд мэхлэсэн буюу бүтээлийн хулгайд тооцдог. Энэ тохиолдолд үүсэх сахилгын дүрэмтэй танилцана уу.

Дунд ангийн сурагчдын гэрийн даалгаварт зарцуулах цаг (ойролцоогоор)

6-р анги	60 минут
7-р анги	75 минут
8-р анги	90 минут
9-р анги	105 минут
10-р анги	115 минут

Үүнээс гадна сурагчид хэл, уран зохиолын хичээлийн нэгэн хэсэг болох унших даалгавруудыг гүйцэтгэх шаардлагатай. Сурагчид онц ач холбогдолтой даалгавар гүйцэтгэх, мөн шалгалтын үеэр дээрхээс илүү хугацаагаар хичээллэж болно.

Дипломын ажлын журам

Дипломын түвшинд суралцах сурагчид дараах даалгавар ажлуудыг хийж гүйцэтгэх хэрэгтэй байдаг. Үүнд: дараагийн хичээлд бэлдэх зорилгоор өгөгдсөн материалыг урьдчилан уншиж судлах, давтах, тэмдэглэл хөтлөх, сурсан мэдлэг чадвараа бататгах, судалгаа хийх, исээ бичих, туршилт хийж тайлагнах, илтгэл хийх гэх мэт тухайн үед гүйцэтгэх хэрэгтэй даалгаврууд дээрээ ажиллах, шалгалтанд бэлдэх, CAS хөтөлбөрийн даалгаврыг хийж гүйцэтгэх зэрэг болно.

Дипломын хөтөлбөрийн сурагчид өгөгдсөн даалгаврыг гэртээ хийж гүйцэтгэх нь сурсан мэдлэгээ нэгтгэх, өмнөх мэдлэгтэйгээ холбох, бодит амьдрал дээр хэрэглэж сурах, бие даан суралцах мөн өөртөө итгэх итгэлийг хөгжүүлэх зорилготой.

"Багш нараас тусламж авч болох хэдий ч та ганцаараа өрөөнд сууснаар олон зүйлсийг сурч болно" Доктор Сьюсс.

Дипломын хөтөлбөрийн сурагчид долоо хоногт ойролцоогоор 15-20 цаг буюу орой болгон 2-3 цагийг хичээлээс гадуур курсын ажил, гэрийн даалгавар, болон бусад бие даан суралцах ажлуудад зарцуулна. Зарим тохиолдолд амралтын өдрүүдээр ч бие даан суралцах шаардлагатай болно. Тухайн курсын ажилд зарцуулах хугацаа нь чадвар, зорилго, хэлний чадвараас шалтгаалан өөр өөр байж болно. Сургууль дээр суралцах цагаа үр дүнтэй өнгөрөөснөөр курсын ажилд гэртээ зарцуулах цагийг багасгаж болдог. Улирлын болон олон улсын чанартай шалгалтын үед цаг хугацаа их зарцуулах шаардлагатайг санах хэрэгтэй.

Сурагчийг урамшуулан шагнах

ОУДС нь олон улсын бакалавриатын түвшний сургалт бүхий тэнцвэртэй боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлдэг бөгөөд сурагчдыг хичээл сургалт, урлаг, спорт, нийгэмшихүй гэсэн 4 чиглэлээр амжилт гаргаж, өсөж дэвжих боломжийг олгодог.

Сурагчид дээрх 4 чиглэлээр амжилт гаргасан тохиолдолд төрөл бүрийн шагнал урамшуулал авах боломжтой. Эдгээр шагналууд багийн систем, спортын хөтөлбөрүүд, жилийн эцсийн шагнал урамшуулалын хүрээнд зохион байгуулагддаг.

Сурагчдад **шагнал олгох зөвлөл нь**

Эцэг эх, сурагчийн гарын авлага

- ОУДС -ийн зорилгуудыг идэвхижүүлэх
- Сургууль хамт олныг бэхжүүлэх
- Сурагчдын манлайллыг идэвхижүүлэх
- Сурагчдын хичээл зүтгэл, амжилтыг нийтэд таниулж, тэмдэглэх гэсэн зорилтын дор шагнал олгох хөтөлбөрүүдээ тогтмол боловсронгуй болгосоор ирсэн.

Хичээлийн жилийн дундуур болон эцэст сурагчдад олгох шагнал урамшуулал:

- 5-р ангийн сурагчдад олгох бага сургуулийн хөтөлбөрийг амжилттай дүүргэснийг тодорхойлох гэрчилгээ
- Тухайлсан хичээлээр сурлагын амжилт гаргасан дунд, төгсөх ангийн сурагчдад олгох шагнал
- CIS олон улсын сурагчдын шагнал, EARCOS глобал иргэншил шагнал
- Спортын төрөл бүрийн шагнал
- Урлагийн төрөл бүрийн шагнал
- Дунд, бага сургуулийн сурагчдад олгох Найрамдалт иргэн шагнал

12-р ангийн төгсөлтийн үйл ажиллагаан дээр дараах шагналаар сурагчдыг шагнаж урамшуулна. Үүнд:

- Хичээл, сурлагадаа амжилт гаргасан сурагчийг шагнах Багш, ажилчдын нэрэмжит шагнал /төгсөлтийн үйл ажиллагаан дээр сургуулийн захирал гардуулна/
- Нийгэм, олон нийтийн ажилд идэвхтэй оролцсон сурагчдад олгох Эцэг эх, багш нарын бүлгийн нэрэмжит шагнал /Эцэг эх, багш нарын бүлгийн тэргүүн гардуулна/
- Идэвхтэй удирдаж манлайлсан сурагчдад олгох Сургуулийн Удирдах Зөвлөлийн нэрэмжит шагнал /Удирдах зөвлөлийн тэргүүлэгч гардуулна/

Сурагчдын ОУДС дээр биеэ авч явах соёл, зан байдалд тавигдах шаардлага

Тус сургуулийн сурагчдын сургууль дээрх зан харьцаа, соёлын үндэс нь өөрийгөө, бусдыг, нийгэм хамт олныг хүндэтгэн үзэх зарчим юм.

Сурагчдад сургууль дээр байх, сургуулиас ивээн тэтгэсэн ямарваа үйл ажиллагаанд оролцож байх үед дараах шаардлагуудыг тавина.

Тус сургуулийн сурагчид нь:

- Сургуульдаа цагтаа ирж, хичээл эхлэхэд бэлэн болсон байх
- Ангид гүйцэтгэх дасгал ажил, гэрийн даалгаваруудыг өөрийн бүхий л боломжоо дайчлан хийж дуусгах
- Сургуулийн хүрээллийн бүх бүлэг, гишүүдэд хүндэтгэлтэй хандах
- Сургуулийн болон бусдын эд хөрөнгийг хүндлэх
- Үнэнч, итгэл даахуйц, шударга байх
- Анги хамт олон, найз нарынхаа зан байдал, итгэл үнэмшил, эрх үүрэгт хүлээцтэй хандаж, тэднийг хүндлэх
- Бусдын сурч боловсроход саад хийхгүй байж тэдний эрхийг нь хүндлэх

Эцэг эх, сурагчийн гарын авлага

- Зөв зохистой, цэвэр хувцаслах
- Сургуулиас хориглосон зүйлсийг авчрахгүй, хариуцлагатай хандах
- Хичээлийн эрхлэгчээс урьдчилан зөвшөөрөл аваагүй тохиолдолд гэрийн тэжээмэл амьтан сургууль дээр авчрахгүй байх
- Сургуулиа цэвэр үзэмжтэй, аюулгүй байлгах
- Сургуулийн орчинд бусдын болон өөрийн аюулгүй байдлыг хангаж, ухаалаг, ухамсартай байх

Бүх эцэг эх, сурагчид сургууль дээр тавигдах зан байдлын шаардлага, хүндлэлийн суурь зарчмуудтай танилцсан байх ёстой. Эдгээр шаардлага, зарчмыг биелүүлээгүй тохиолдолд ОУДС -ийн Зан байдлыг удирдах дүрмийн дагуу зохих шийтгэл хүлээнэ гэдгийг мэдэх хэрэгтэй.

Зан байдлыг удирдах дүрэм

Зан байдлыг удирдах дүрмийн зорилго нь ОУДС -ийн бүх сурагчдыг сурч боловсрох эерэг дулаан орчин нөхцлөөр хангах явдал юм. Сурагчид сургууль дээр байх, сургуулийн гадаад дотоод үйл ажиллагаанд оролцож байх үедээ гаргасан зохисгүй зан байдалдаа бүх багш, ажилтан, ажилчдын өмнө хариуцлага хүлээнэ гэдгээ ухамсарлах ёстой.

Хичээлийн жилийн эхэнд Зөвлөх багш болон анги удирдсан багш нар сурагчдад Зан байдлыг удирдах дүрмийг тайлбарлан таниулах үүрэгтэй. Захиргааны ажилтан болон багш нар нь сурагч, тэдгээрийн эцэг эх, асран хамгаалагчтай үүссэн зөрчлийг шийдэх талаар бүхий л бололцоогоо дайчлан ажиллана. Энэхүү Зан байдлыг удирдах дүрмийн хэрэгжилт нь ямар ч үед шударга, үндэслэлтэй байх ёстой. ОУДС-ийн багш, ажилтнууд сурагчдын гаргасан зохисгүй зан байдлыг тэдний өсөлт хөгжилтөнд эерэг нөлөө үзүүлэхүйц арга замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

Зан байдлын зөрчлийн түвшингүүд

Сурагчийн зан байдлын зөрчлийг **бага, ноцтой, маш ноцтой** гэж авч үзнэ.

1-р түвшин: Бага хэмжээний зөрчил: Үүнд (Доорх жагсаалтаар хязгаарлагдахгүй):

1. Хичээлд хожимдож ирэх
2. Даалгаврыг тогтоосон хугацаанд нь гүйцэтгээгүй, эсвэл огт хийхгүй байх
3. Хичээл заах үйл ажиллагааг тасалдуулсан зохимжгүй зан байдлыг ангид гаргах
4. Бусдыг үл хүндэлсэн үг хэлэх, үйлдэл хийх
5. Бусдыг доромжилсон, гомдоосон тохиромжгүй үг хэллэг хэрэглэх
6. Нийтийн дунд биеэ зөв авч явахгүй байх
7. ОУДС -ийн зөв хувцаслалтын дүрмийг баримтлахгүй байх

Дээрх бага хэмжээний зөрчил гаргасан тохиолдолд авах арга хэмжээ:

Алхам 1: Сурагчийн гаргасан зохисгүй зан байдлыг засахын тулд багш тухайн сурагчтай үүсээд буй нөхцөл байдлын талаар биечлэн ярилцаж хэлэлцэнэ.

Алхам 2: Багш сурагчийн гаргасан тухайн зөрчилд тохирох арга хэмжээ авна. /Тухайлбал, Хоолны цагаар эсвэл хичээлийн дараа авч үлдэх шийтгэл /

Эцэг эх, сурагчийн гарын авлага

Алхам 3: Хэрэв тухайн сурагчийн зохисгүй зан үйлдэл үргэлжилсээр байвал энэ талаар бичгээр ирүүлсэн мэдээллийн дагуу Дунд, Бага сургуулийн удирдлагууд тухайн сурагч болон багштай хамтран асуудлыг хэлэлцэж, цаашид авах арга хэмжээг тодорхойлно.

2-р түвшин: Ноцтой зөрчил

Ноцтой зөрчил гарсан даруйд сургуулийн багш, ажилчид энэ талаар бага, дунд сургуулийн удирдлагад яаралтай мэдэгдэх хэрэгтэй.

Ноцтой зөрчил (Доорх жагсаалтаар хязгаарлагдахгүй):

1. Тухайн улс үндэстний соёлыг болон хувь хүнийг үг хэлээр, бичгээр, дохио зангаагаар доромжлох
2. Бусад сурагчдыг үг хэл, дохио зангаагаар айлган сүрдүүлэх, заналхийлэх
3. Бусдын бие махбодод түрэмгийгээр хүрэх, цохих зодолдох
4. Анги хамт олныг хагалан бутаргах, зөрчилдүүлэх
5. Багш, ажилчдад худал хэлэх
6. Оюуны бүтээл хулгайлах, хууран мэхлэх /гэрийн даалгавар, бие даан гүйцэтгэх ажил, төстийн хариултыг бие биедээ дамжуулах/
7. Зөвшөөрлийн хуудас, дүнгийн тайлан, үйл ажиллагааны тайлан болон сургуулийн бусад харилцаанд эцэг эх, асран хамгаалагчийн гарын үсгийг хуурамчаар үйлдэх
8. Хичээл, үйл ажиллагааг шалтгаангүйгээр таслах, эцэг эхийн зөвшөөрөлгүйгээр сургуулиас гарч явах
9. Сургуулийн техник технологи, эд хөрөнгөд зүй бусаар хандах /Хүлээн зөвшөөрөгдөхүйц ашиглалтын гэрээнд заасан, мөн бусад эвдрэл хохирол энд хамаарна. Доорх бүлгийг харна уу/
10. Нураан сүйтгэх, хана, хаалга, хичээлийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг муутгах гэх мэт сургууль, бусад хүмүүсийн эд хөрөнгийг сүйтгэх, гэмтээх санаатай үйлдэл хийх.

Оюуны бүтээл хулгайлах

Оюуны бүтээл хулгайлах гэдэг нь бусдын санаа бодол, зохиол бүтээл, ажлыг зөвшөөрөлгүйгээр ашиглах явдал юм. Эх үүсвэрийг тодорхой зааж өгөөгүйгээс бусад тохиолдолд бусдын хийж бүтээсэн бүтээл ажлаас хуулбарлан оруулсан ямар нэг материал нь оюуны бүтээл хулгайлсанд тооцогдоно.

Бүтээл ажилдаа бусдын ажлын тодорхой хэсгийг, бүхлээр нь дараах байдлаар өөрийнхөө нэрээр ашигласан тохиолдолд оюуны бүтээл хулгайлсанд тооцогдоно.

Үүнд:

1. Бусад сурагчдын исээ, даалгавар, төслөөс хуулах
2. Вэбсайтаас баримтуудыг хуулах
3. Хэвлэмэл бүтээл, ном, бусад эх үүсвэрээс хуулах
4. Хэн нэгнээр өөрийгөө төлөөлж бичүүлэх, хийлгэх
5. Тодорхой эх үүсвэрийг заалгүйгээр өөрийн болгон бичих
6. Ишлэлийн эх үүсвэрийг дурдалгүй хэрэглэх.

Ноцтой зөрчил гарсан тохиолдолд авах арга хэмжээ:

Эцэг эх, сурагчийн гарын авлага

Алхам 1: Уг зөрчлийг магадлан шалгасны эцэст сурагч, багш, бага, дунд сургуулийн удирдлагуудын хамтын хурал хийх, эцэг эхэд мэдэгдэж, зохих арга хэмжээ авна. Зарим тохиолдолд зөрчил гаргасан тэр даруйд шийтгэх арга хэмжээ авна. Энэ талаарх баримтыг сурагчийн хавтсанд хадгалан үлдээнэ.

Алхам 2: Хоёр дахь удаа ноцтой зөрчил гаргасан тохиолдолд сурагч, эцэг эх, багш, бага, дунд сургуулийн удирдлагыг оролцуулсан хурал хийж, тухайн сурагч, эцэг эх нь хамтдаа Зан байдлыг сайжруулах төлөвлөгөөнд гарын үсэг зурна. Энэ талаарх баримтыг сурагчийн хавтсанд хадгалан үлдээнэ.

Алхам 3: Гурав дахь удаа ноцтой зөрчил гаргасан, Зан байдлыг сайжруулах төлөвлөгөөг зөрчсөн тохиолдолд сургуулийн захирал тухайн сурагчийн ОУДС-д суралцах эрхийг хязгаарлах арга хэмжээ авч болно. Энэ талаарх баримтыг сурагчийн хавтсанд хадгалан үлдээнэ.

3-р түвшин: Маш ноцтой зөрчлүүд:

Маш ноцтой зөрчил гарсан тохиолдолд бага, дунд ангийн удирдлагуудад яаралтай мэдэгдэх шаардлагатай бөгөөд энэ зөрчлийг сургуулийн захиргааны түвшинд авч хэлэлцэнэ.

Маш ноцтой зөрчил (Доорх жагсаалтаар хязгаарлагдахгүй):

1. Сургууль дээрх хүмүүст, сургуулийн үйл ажиллагаанд аюул учруулж болохуйц эд зүйлс эзэмших
2. Ямар нэгэн багаж зэвсэг, эд зүйлс хэрэглэн бусдыг гэмтээх, гэмтээхийг завдах
3. Сургууль дээр, сургуулийн үйл ажиллагаанд архи тамхи зэрэг хууль бус зүйлсийг хэрэглэх, авч явах
4. Багшийн сургалтын материал, шалгалт, тестийн материалыг санаатайгаар залилан авах, хулгайлах
5. Хулгай хийх, хулгай хийхийг оролдох
6. Шалгалтын материал, дүнгийн тайлан дээрх дүнг өөрчлөх
7. Сексийн дарамт учруулах: үг хэлээр, бие махбодоор, бичгээр эсвэл харцаараа хүсээгүй сексийн харьцаа, анзаарлыг үүсгэх
8. Сургууль дээр болон нийгэм, олон нийтийн дунд сургуулийн нэр хүндэд ноцтой муугаар нөлөөлөх үйлдэл хийх
9. Сургууль дээр, сургуулийн үйл ажиллагаанд порно бичлэгүүдийг үзэх, авч явах.

Маш ноцтой зөрчил гаргасан тохиолдолд авах арга хэмжээ:

Алхам 1: Захирал зөрчил гарсан нэн даруйд тухайн сурагчийг түүний эцэг эх, бага, дунд сургуулийн удирдлага, захирал, сурагчийн хамтарсан хурал хийх хүртэл хичээлд ирэхийг нь түтгэлзүүлнэ. Сурагч ОУДС -д үлдэн суралцахаар болвол Зан байдлыг сайжруулах гэрээг байгуулна. Энэхүү гэрээнд сургууль, сурагч, түүний эцэг эх гарын үсэг зурж баталгаажуулна. Энэ тухай баримтуудыг сурагчийн хавтсанд баримтжуулан хадгална.

Алхам 2: Хэрэв маш ноцтой зөрчлийг дахин гаргасан, Зан байдлыг сайжруулах гэрээг зөрчсөн тохиолдолд сургуулийн захирал сурагчийг сургуулиас хөөх эсвэл зан байдлаа засах боломж өгөх шийдвэр гаргасан

Эцэг эх, сурагчийн гарын авлага

эсэхээ мэдэгдтэл тухайн сурагчийг дахин сургуулиас түдгэлзүүлнэ. Сургуулийн захирал тухайн сурагчийн гаргасан зөрчил, түүнд ногдуулсан сахилгын шийтгэлийн талаар баримт үйлдэх бөгөөд энэ нь сурагчийн хавтасны байнгын хэсэг болно.

Сахилгын шийтгэлийг үл зөвшөөрөх:

Хэрэв сурагч өөрийгөө зөрчил гаргасанд буруугүй, сахилгын шийтгэл хэт хатуу гэж үзэж байвал шийдвэрийг зөвшөөрөхгүй байж болно.

1. Сурагч асуудалд өөрийгөө өмгөөлөх эрхтэй. Үүнд: баримт, нотолгоог шаардах, гэрчүүдийг байлцуулах, орчуулагчтай байх, дэмжих хүнийг оролцуулах эрх орно.
2. Эсэргүүцэх үйл явц нь доорх журмаар явагдана.
 - а. Бага зэргийн зөрчилд багш сахилгын шийтгэл ногдуулсан тохиолдолд зөвхөн багш сурагч хоёр асуудлыг хэлэлцсэний дараа сурагч тухайн асуудлыг бага, дунд сургуулийн удирдлагуудад хандаж мэдэгдэнэ.
 - б. Хэрэв сахилгын шийтгэлийг бага, дунд сургуулийн эрхлэгч ногдуулсан бол сурагч эхлээд бага, дунд сургуулийн эрхлэгчидтэй хэлэлцсэний дараа сургуулийн захиралд хандаж мэдэгдэнэ.

Хэрэв сурагч захиралд хандан үл зөвшөөрсөн тухайгаа мэдэгдсэн тохиолдолд бага, дунд сургуулийн эрхлэгч сахилгын шийтгэл ногдуулсан тухайн хичээлийн өдөрт багтаан захиралтай уулзалт товлон.

Захирал тухайн сурагчтай болон бусад хамаарагдах хүмүүстэй уулзаж хэлэлцэн, гаргасан шийдвэрээ аль болох түргэн бичгээр мэдэгдэнэ.

Хувцаслалтын дүрэм

Сургуульд ирэхдээ зохимжтой хувцаслах нь бүх сурагч, ажиллагсдын хариуцлага мөн. Сурагчдын хувцаслалтад дараах гурван гол зарчим байдаг. Үүнд:

1. Сурагчийн хувцас нь олон өөр соёл бүхий сурагчид суралцдаг аль ч олон улсын сургуулийн хэм хэмжээ, эрэлтийг хүндэтгэсэн байх шаардлагатай. Хэн нэгний соёл, итгэл үнэмшлийг зөрчсөн, үл ойшоосон хувцас өмсөхгүй байх хэрэгтэй.
2. Сурагчид байнга цэвэр үзэмжтэй, хичээл, суралцах орчинг сарниулахгүй байдлаар хувцаслах хэрэгтэй. Эрээ цээргүй, хэт задгай, бусдын анхаарлыг эрс татахуйц хувцаслахыг хориглоно*.
3. Сурагчид цаг агаарт тохируулан хувцаслах хэрэгтэй. Энэ нь сурагчид гадаа болох үйл ажиллагаанд оролцох, хичээлийн завсарлагаанаар гарах, биеийн тамирын хичээл гадаа явагдахад чухал байдаг**.

Жич:

* Хориотой хувцаслалт: өвдөгнөөс дээш 15 см болон түүнээс богино банзал, шорт, сэтэрч ханзарсан, уранхай хувцас, цээж ил гаргасан цамц, өндөр өсгийтэй гутал (5см-с өндөр өсгийтэй), хөлийн хуруу гарсан шаахай, анхаарал хэт татахуйц төрөл бүрийн хувцас, зохисгүй уриа, бичиг бүхий цамц, футболка

** Бага сургуулийн сурагчид сургууль дотор өмсөх биед эвтэйхэн гуталтай байна. Сургуульд ирэхдээ тухайн цаг агаарт тохируулан хувцаслаж ирнэ (бээлий, малгай,

Эцэг эх, сурагчийн гарын авлага

өвлийн дулаан хүрэм, ороолт, өвлийн улиралд бага насны хүүхдүүд цасны өмд өмсөх гэх мэт).

Мэдээлэл, харилцаа холбооны технологийн (ICT) зөв зохистой хэрэглээг зохицуулах

ОУДС -д мэдээлэл, харилцаа холбооны технологи ашиглах нь судалгаа шинжилгээ хийх боломжийг бүрдүүлэх, мэдээ, мэдээлэл харилцан солилцох, багш, ажилчид, сурагчдын хоорондын харилцааг өргөжүүлэхэд оршино. Интернет орчинд холбогдож ажиллах нь энд мөн хамаарна. Хэрэглэгчид сургуулиас хэрэгжүүлж байгаа журмыг мөрдөх ёстой. Сүлжээнд холбогдсон хэрэглэгчид анги танхим, сургууль дотор баримтлах стандарт шаардлагуудыг даган мөрдөж эрх үүргээ ухамсарлан, хариуцлагатай байх ёстой.

Мэдээ мэдээллийн системийг ашиглаж буй бүх хэрэглэгчдэд хариуцлагатай, ёс зүйтэй, зохистой, боловсон, мэргэжлийн түвшинд биеэ авч явахыг сургууль шаардана.

Сурагчид мэдээлэл, харилцаа холбооны технологи (ICT) ашиглах гэрээнд заагдсан эрх үүрэг, хүлээх хариуцлагыг уншиж танилцан, гэрээнд гарын үсэг зуран ангийн багшид хүлээлгэн өгнө.

Цэцэрлэгийн наснаас 4 хүртлэх ангийн сурагчдад зориулсан мэдээлэл, харилцаа холбооны технологи (ICT) ашиглах гэрээ

Сурагчид сургуулийн компьютер, сүлжээг ашиглахдаа дараах дүрмүүдийг дагаж мөрдөнө. Ямар нэгэн зөрчил гаргасан тухайд сургуулийн зүгээс эцэг эхэд нь мэдэгдэж, тухайн сурагчийн компьютер ашиглах хугацааг түр түтгэлзүүлэх буюу бусад арга хэмжээг авна.

Хүндэтгэлтэй хандах

- Би зөвхөн багш нарын зөвшөөрлөөр сургуулийн компьютерийг хэрэглэнэ.
- Би бусад сурагчдын хийсэн ажилд хүндэтгэлтэй хандана.
- Би зөвхөн багшийн зөвшөөрөлтэйгөөр өөрийн хийсэн ажлаа хэвлэнэ.
- Би компьютер дээр ажилласны дараа бүх зүйлийг анх байснаар нь үлдээдэг.

Аюулгүй байх

- Би компьютерийг хайр гамтай хэрэглэнэ.
- Би багш, эцэг эхээс бусад хүнд өөрийн нууц үгийг хэлэхгүй.
- Би нээх ёсгүй аливаа хавтас (file), программыг нээхгүй.
- Би зөвхөн багшийн зөвшөөрлөөр мэдээлэл, зураг, файлыг бусадтай хуваалцана.
- Хэрвээ надад тааламжгүй мэдээлэл гарч ирвэл би багшдаа шууд хэлнэ.

Хариуцлагатай байх

- Би компьютер дээр ажилласны дараа бүх программ, аппликэйшнуудыг хаана.
- Би компьютер дээр ажиллаж дууссаны дараа байнга өөрийн цахим шуудан болон бусад хаягуудаас гарч байж компьютерийг хаана.
- Би компьютерийн түүхэн мэдээллийг устгахгүй.

Эцэг эхээс компьютер хэрэглэх зөвшөөрөл олгох: Мэдээлэл, харилцаа холбооны технологи ашиглах гэрээнд эцэг эхээс авсан дараах зөвшөөрөл багтдаг. Үүнд:

Би хүүхдийнхээ сургуулийн сүлжээ, интернэт, түүнд холбогдсон компьютер ашиглахыг зөвшөөрч байна.

Сургуулийн зүгээс сурагчдын нас, үүрэг хариуцлага зэрэгт тохирсон хяналт тавин, удирдан чиглүүлэх хэдий ч тухайн сурагчийн олж авсан ямар нэгэн зохисгүй материалд хариуцлага хүлээхгүй гэдгийг би ойлгож байна.

Миний бие хүүхэддээ мэдээ, мэдээлэл болон хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглах, бусдад түгээх, хайх, судлах үед нь дагаж мөрдөх шаардлагатай стандарт хэм, хэмжээг бий болгон даган мөрдүүлэх үүрэгтэйгээ хүлээн зөвшөөрч байна.

Би хүүхдийнхээ сургуулийн сүлжээг зохимжтой бус байдлаар хэрэглэсэн явдлыг сургуульд тайлагнахыг зөвшөөрч байна.

5-12-р ангийн сурагчдын мэдээлэл, харилцаа холбооны технологи (ICT) ашиглах гэрээ

Сургуулийн мэдээлэл, харилцаа холбооны технологийг зөвхөн боловсрол олж авах зорилгоор ашиглана. Ингэхдээ дараах дүрмийг чанд сахина. ОУДС -ийн мэдээлэл, харилцаа холбооны технологи хэрэглэгчид нь:

1. Бусдын хувийн нууцыг хүндэтгэн хамгаалах...

- а. Зөвхөн ОУДС-с олгосон хаягийг ашиглана. ОУДС-с олгосон цахим шуудангийн хаяг нь тус сургуульд хэрэглэгдэх цорын ганц цахим шуудангийн хаяг байна. (Төгсөх ангийн сурагчдад хамаарахгүй).
- б. Зөвшөөрөгдсөн вэб-сайт, сүлжээ, мэдээллүүдийг боловсрол олж авах зорилгоор ашиглана.
- в. Өөрийн болон бусдын хувийн мэдээллийг байрлуулахгүй байх (жишээлбэл: нэр, цахим шуудангийн хаяг, гэрийн хаяг, утасны дугаар гэх мэт). Бусдад нууц үгээ мэдээлэхгүй байна.
- д. Сургуулийн үйл ажиллагаа, сурагчид болон ажилтан албан хаагчдын талаархи мэдээллийг олон нийтэд дэлгэхгүй байх. (Тухайлбал: спортын үйл ажиллагаа урлагийн тоглолт, аялал зугаалга, анги, хамт олны төсөл, урлагийн бүтээл, илтгэл, хичээл г.м) Зөвхөн сургуулиас олгосон зөвшөөрлөөр нийтэлнэ.
- е. Цахим ертөнцөд бусдыг дарамтлах, дээрэлхэх, доромжлох үйл явдалд оролцохгүй байх. ОУДС нь цахим ертөнцөөр бусдыг дарамтлах, дээрэлхэх, доромжлох үйл явдлыг хүлээн зөвшөөрдөггүй. Сурагчид хоорондоо эсвэл гаднаас ОУДС-ийн сурагчдын аюулгүй байдал, аж амьдралд нь сөргөөр нөлөөлсөн материалыг нийтэлсэн, илгээсэн этгээдийн эсрэг сургуулийн захиргаа арга хэмжээ авах эрхтэй.

2. Мэдээлэл, харилцаа холбооны технологийн аюулгүй болон бүрэн бүтэн байдлыг хамгаалах, хүндэтгэлтэй хандах...

- а. Сүлжээний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн тогтоосон журмыг дагаж мөрдөнө. (Жишээлбэл: хорлох, сүйтгэх сэдэлтэйгээр кодыг тараахгүй байх, сургуулийн компьютерийг нээлттэй чигээр нь орхихгүй г. м)

Эцэг эх, сурагчийн гарын авлага

- б. Аюулгүй байдалд эрсдэл учруулж болохуйц зөрчил гэмтлийг багш, захиргааны ажилтнуудад мэдээлдэг байна.
- в. Багш, захиргааны ажилчдын шаардлагын дагуу тэднийг ОУДС-н өөрийн хаяганд нэвтрэх боломж өгөх.
- г. Сургуулийн мэдээлэл, харилцаа холбооны технологийн нөөц бололцоог зөв зохистой байдлаар хуваалцах, хадгалах, хамгаалах.
- д. Интернетийг зөв зохистой хэрэглэх.
- е. Мэдээлэл, харилцаа холбооны технологийн нөөц бололцоо, сургуулийн сүлжээ, аливаа программын өгөгдлийг хуурамчаар үйлдэхгүй байна.

3. Бусдын оюуны өмчийг хамгаалан хүндэтгэлтэй хандах...

- а. Оюуны өмч болон зохиогчийн эрхийн тухай хуулиудыг дагаж мөрдөнө (аливаа программ, хөгжим, киног хууль бусаар хуулбарлахгүй байна).
- б. Интернетийн мэдээллүүдийг судалгаандаа иш татаж ашиглах.
- в. Бүтээлийн хулгайгаас зайлсхийх.

4. Нийгмийн нийтлэг зарчмуудыг даган мөрдөх, хүндлэх...

- а. Бусдад хүндэтгэлтэй хандах зарчмаар техник, технологийг ашиглах, харилцан мэдээлэл солилцох.
- б. Аливаа заналхийлсэн эсвэл аюултай байж болохуйц мэдээллийн талаар багш ажилчдад мэдэгдэх
- в. Цахим материалыг бүтээх, хуулах, шилжүүлэх, ашиглахдаа ОУДС-ийн ёс зүйн дүрэм болон Монгол улсын холбогдох хууль дүрмийг баримтлана. Бүдүүлэг, заналхийлсэн, ялгаварлан гадуурхсан, айлган сүрдүүлсэн, бусдыг гутаан доромжилсон мессежүүдийг үл хүлээн зөвшөөрнө.
- г. Ухуулан ятгасан, бусдын дүргүйг хүргэсэн болон олон нийтийн эсрэг чиглэсэн и-мэйл, захидал явуулахгүй байх.
- д. Худалдах, худалдан авах, зар сурталчилгаа хийх гэх мэт бизнесийн үйл ажиллагааг зөвхөн сургуулийн захиргаанаас олгосон зөвшөөрлийн дагуу хийх бөгөөд тэдгээр нь сургуулийн үйл ажиллагаатай холбоотой байна.
- е. ОУДС дээр олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглах, тоглоом тоглох зэрэг нь хориотой бөгөөд зөвхөн сургуулийн захиргаанаас урьдчилан зөвшөөрөл авсан үед хүлээн зөвшөөрөгдөнө.

Мэдээлэл, харилцаа холбооны технологийн гэрээг зөрчсөн тохиолдолд авах арга хэмжээ:

Гэрээний нөхцлүүдийг даган биелүүлээгүй ямар ч тохиолдолд сурагчдад **Сурагчийн зан байдлын журамд** дэлгэрэнгүй дурдагдсан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

ХОЛБОГДОХ ХАЯГ

Шуудангийн хаяг

Монгол улс-17032
Улаанбаатар хот
Олон Улсын Дунд Сургууль
Төв Шуудан Ш/Х 36/10
Утас: +97670160010/20

Хүлээн авагч
Захиргаа (ерөнхий)
Санхүүгийн алба
Бага сургуулийн хөтөлбөрийн зохицуулагч
Дунд сургуулийн хөтөлбөрийн зохицуулагч
Дипломын хөтөлбөрийн зохицуулагч
Бага сургуулийн хичээлийн эрхлэгч
Ахлах Сургуулийн хичээлийн эрхлэгч
Гүйцэтгэх захирал
Захирал

Байршлын хаяг

Монгол Улс, Улаанбаатар хот
Хан-Уул дүүрэг, 15-р хороо
Дөрвөн Улирал Цэцэрлэг
Их Монгол Улсын Гудамж-63
Олон Улсын Дунд Сургууль
Website: www.isumongolia.edu.mn

reception@isumongolia.edu.mn
administration@isumongolia.edu.mn
finance@isumongolia.edu.mn
purpcoordinator@isumongolia.edu.mn
mypcoordinator@isumongolia.edu.mn
dpcoordinator@isumongolia.edu.mn
primaryhead@isumongolia.edu.mn
secondaryhead@isumongolia.edu.mn
depdirector@isumongolia.edu.mn
director@isumongolia.edu.mn

Багш нартай ISU website дээрх faculty & staff directory link-ээр дамжин харилцана уу.

Эцэг эх, сурагчийн гарын авлага

Хүндэт эцэг эх, сурагчдаа,

Бид ОУДС -ийн үйл ажиллагааны талаар та бүхэнтэй олон арга замаар холбогддог билээ. Та бүхэн өдөр бүр манай сургуулийн вэбсайтаар зочилж шинэ мэдээ, мэдээллийг авч болохоос гадна өөртөө хамааралтай мэдээллийг эцэг эхчүүдийн порталаас дэлгэрүүлэн үзэх боломжтой. (www.isumongolia.edu.mn)

Энэхүү Эцэг эх, сурагчийн гарын авлага нь ОУДС -ийн үйл ажиллагааг таниулах нэг арга зам юм. Энэ гарын авлагад хамгийн чухал мэдээллүүдийг багтаасан бөгөөд эдгээр нь таны цаашдын үйл ажиллагаанд хэрэг болно гэдэгт найдаж байна. Бид сурагчиддаа хэвлэмэл хувийг тараах бөгөөд сургуулийн вэб сайтаас энэхүү гарын авлагыг цахим хэлбэрээр харах боломжтой.

Бид гарын авлагад ороогүй мэдээллийн талаарх санал хүсэлтийг дуртайяа хүлээн авах болно. Та бүхэн санал хүсэлтээ administration@isumongolia.edu.mn хаягаар илгээх, эсвэл энэхүү хуудасны доод хэсэгт бичиж бидэнд ирүүлэх боломжтой.

Эцэг эх, сурагчид та бүхэн энэхүү хуудасны доод хэсгийг бөглөн, таслан авч ангийн багш /бага сургуулийн/, зөвлөх багш /дунд сургуулийн/ нартаа өгнө үү.

Би энэхүү 2018-2019 оны хичээлийн жилийн Эцэг эх, сурагчийн гарын авлагыг уншиж танилцсанаа гэрчилж гарын үсэг зурав.

Огноо: _____

Сурагчийн нэр: _____

Эцэг эхийн нэр: _____

Эцэг эхийн гарын үсэг: _____

САНАЛ ХҮСЭЛТ:

General PYP IB Vocabulary - Түлхүүр үгсийн орчуулга

ENGLISH	MONGOLIAN
1. appreciation	талархал
2. attitudes (Behaviors that students must value and demonstrate)	хандлага
3. balanced	өв тэгш
4. caring	Халамжтай хүнлэг энэрэнгүй
5. commitment	Зориулалттай
6. communicator	Харилцагч
7. communication skills	харилцах ур чадвар
8. community	Хамт олон, нийгэм, нийгэмлэг,
9. confidence	өөртөө итгэлтэй байх
10. continuum	Тасралтгүй холбоо
11. cooperation	Хамтран ажиллах
12. creativity	Бүтээлч
13. curiosity	Сониуч
14. empathy	бусдыг ойлгох чадвар
15. enthusiasm	урам зоригтой, санаачлага
16. IB Primary Years Program (PYP)	Бага ангийн хөтөлбөр
17. IB Middle Years Program (MYP)	Дунд ангийн хөтөлбөр
18. IB Diploma Program (DP)	Ахлах ангийн хөтөлбөр
19. IB Learner Profile	Сурагчийн эрхэм чанар
20. independence	бие даан ажиллах чадвар
21. International Baccalaureate (IB)	Олон Улсын Бакалавриат Хөтөлбөр
22. inquirer	судалгаа шинжилгээ, судалгаа лавлагаа эрэлхийлэл, эрэлт хэрэгцээ эрэлхийлэгч
23. integrity	шударга
24. international mindedness	\олон үндэстний\ өргөн сэтгэлгээтэй
25. knowledgeable	өргөн мэдлэгтэй
26. Mission Statement	Эрхэм зорилго
27. open-minded	бусдын үзэл бодолд хүндэтгэлтэй хандагч

Эцэг эх, сурагчийн гарын авлага

28. principled	зарчимч
29. reflective	дүгнэн бодогч
30. research skills	судалгааны чадвар
31. respect	хүндлэл
32. risk-taker	Эрсдэл үүрэгч
33. self-management skills	хувийн зохион байгуулалтын чадварууд
34. skills (What we want students to be able to do)	чадвар
35. social skills	нийгэмших чадвар
36. thinker	сэтгэгч
37. thinking skills	Сэтгэн бодох чадвар
38. tolerance	Тэсвэр тэвчээртэй
39. creativity	Бүтээлч байдал